

ТАЙЛАН

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ

2022 ОНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2023 он

Хянан тохиолдуулсан:

Тайланг нэгтгэн
боловсруулсан:

Эх бэлтгэсэн:

Ядамжавын Цэлмэн

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал
эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор (Ph.D)

Бурмаагийн Эрдэнэбилэг

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн
дарга

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтэс

Гиваасамбуугийн Дэлгэрбаяр

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн
ахлах мэргэжилтэн

**ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ
АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТАЙЛАН**

УДИРТГАЛ	1
НЭГ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭТГЭЛ	
1.1. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын хэрэгжилт	3
1.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт	7
ХОЁР. ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ, ХУУЛЬ БУСААР БАРИВЧЛАХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ГЭМТ ХЭРГҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ, СТАТИСТИКТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	
2.1. Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл	10
2.2. Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн тухай гомдол мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн статистик	12
ГУРАВ.ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ	
3.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийгдсэн хяналт шинжилгээ	16
3.2. Цагдаагийн байгууллагад хийгдсэн хяналт шинжилгээ	26
3.3. Ахмад настны Үндэсний төвд хийгдсэн хяналт шинжилгээ	31
3.4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хийгдсэн хяналт шинжилгээ	37
ДӨРӨВ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА	
4.1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалтын чиглэлээр	44
4.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны чиглэлээр	45
ТАВ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ	
5.1. Олон улсын байгууллагатай хамтран ажилласан талаар	47
5.2. Иргэний нийгмийн болон ашгийн төлөө бус төрийн бус байгууллагатай хамтран ажилласан талаар	54
5.3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага	53
ЗУРГАА. ДҮГНЭЛТ	59
ДОЛОО. САНАЛ	61
НАЙМ. ХАВСРАЛТ	63

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР	АТГ
АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ	АНҮТ
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА	НҮБ
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ	ОУБ СЭМҮТ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ	ТАЗ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА	ТББ
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР	УЕПГ
УЛСЫН ИХ ХУРАЛ	УИХ
ҮНДЭСНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙГУУЛЛАГА	ҮУСБ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР	ХХҮЕГ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР	ХХҮГ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО	ХЗБХ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ	ХЗДХЯ
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС	ХЭҮК
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР	ЦЕГ
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	ШЕЗ
ШҮҮХИЙН СЭТГЭЦ ЭМГЭГ СУДЛАЛЫН КЛИНИК	ШСЭСК
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА	ШШГ байгууллага
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР	ШШГЕГ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ	ШШГТ ХУУЛЬ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ	ЭХХШТХУУЛЬ
ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ	ЭШУС
ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ	ЭШЭК
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ	ЭМЯ

УДИРТГАЛ

Эрүү шүүлт болон хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрх нь Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын эрх зүйн дагуу хэзээ ч хязгаарлаж үл болох туйлын (абсолют) эрх. ... өөрөөр хэлбэл, ямар ч үндэслэлээр энэхүү эрхийг хязгаарлахыг хориглодог. Учир нь, эрүү шүүлт нь хүний нэр төр, ардчилсан нийгмийн иргэншсэн зан үйлийн хэм хэмжээг ноцтойгоор зөрчдөг учраас эрүү шүүлтийг хориглосон хориглолтоос илүү чухал ашиг сонирхол гэж байхгүй....¹

Эмнести Интернэшнл 2022/23 тайланд “Олон орны эрх баригчид хүний амьд явах эрх, эрх чөлөө, шударгаар шүүлгэх, бие махбодын халдашгүй байх эрхийг зөрчсөөр байна. Эдгээр зөрчил нь ихэвчлэн улс төрийн хямрал, онц байдлын үед Засгийн газрын авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ эсхүл аюулгүй байдлыг хангах болон шүүн таслах байгууллагуудаас хууль бус дур зоргоороо, тухайн нөхцөл байдлын хэр хэмжээнд нийцээгүй хариу арга хэмжээ хэрэгжүүлэх явцад гардаг...” гэж дүгнэжээ.²

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, 1987 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц /цаашид ЭШЭК гэх/-д Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталжээ.

Энэхүү конвенцод нэгдэн орсон оролцогч улсуудад эрүү шүүлттэй тэмцэх, түүнд өртсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байдаг.

Улмаар Монгол Улсын Улсын Их Хурлаас ЭШЭК-ын Нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр баталснаар 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах үүрэг хүлээсэн.³

Нэгдсэн Үндэстний байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 дүгээр сарын 11-нээс 20-ны өдрүүдэд ЭШЭК, түүний Нэмэлт протоколын хүрээнд олгогдсон эрхийн дагуу айлчлалын хүрээнд “18.... үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг үүсгэн байгуулахдаа Нэмэлт протокол, үндэсний урьдчилан сэргийлэх механизмын талаарх Дэд хорооны Удирдамжтай бүрэн нийцсэн байхыг анхаарах нь зүйтэй. Иргэний нийгмийн байгууллага, бусад оролцогчдыг хамруулан ил тод ажиллагааны дунд олон нийтээр хэлэлцүүлэн үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг байгуулах нь зүйтэй.” гэж зөвлөжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.12-т “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.” гэж заасан.⁴

¹ Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал /тойм судалгаа/ УБ, 2021 он 21 дэх тал

² www.amnesty.mn болон Эмнести Интернэшнлийн 2022 /23 тайлан “Дэлхий дахины Хүний эрхийн төлөв байдал баримт бичиг” УБ, 29 дэх тал

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10795> Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын нэмэлт протокол соёрхон батлах тухай Монгол Улсын хууль

⁴ <https://legalinfo.mn/mn/detail/15586>

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчлэн батлахдаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний бүрэн эрх, чиг үүрэг, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгасан.⁵

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд заасан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр хууль зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай байх шаардлагын үүднээс УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны олон талт төлөөлөл оролцсон Комиссын олонхын саналаар 7 үе шатны сонсгол буюу 1.6 жил үргэлжилсэн 2 дахь удаагийн нээлттэй сонгон шалгаруулалтаар хууль зүйн ухааны доктор Ядамжавын Цэлмэн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Улсын Их хурлын 29 дүгээр тогтоолоор томилогдсон.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлнэ.” гэж заасны дагуу ЭШУС үндэсний ажиллагааны 2022 оны тайланг бэлтгэн танилцуулж байна.

Иймд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн томилогдсон 2022 оны 06 дугаар сарын 02, түүнд туслах чиг үүрэг бүхий нэгжийн албан хаагчид томилогдсон 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс хойших хяналт шинжилгээ, сургалт, сурталчилгаа, хамтын ажиллагаа, төрийн байгууллагуудын албан ёсны мэдээлэл, бусад судалгаа, эх сурвалжид үндэслэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны тайланг 2023 оны 04 дүгээр сар хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамааруулан боловсрууллаа.


⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15152>

НЭГ.ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭТГЭЛ

1.1. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын хэрэгжилтийн өнөөгийн байдал

ЭШЭК-ын Нэмэлт протоколын 3 дугаар зүйлд “Оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага байгуулах, томилох, эсхүл хэвээр ажиллуулах үүрэг хүлээнэ” гэж заасан бөгөөд оролцогч улсуудад ЭШУС үндэсний байгууллага байгуулах үүргийг хүлээлгэсэн.

1.1.1. Бусад улсын ЭШУС үндэсний байгууллага



2023 оны 03 дугаар сарын байдлаар ЭШЭК-ын Нэмэлт протоколд нэгдсэн орсон 91 улсаас 72 нь ЭШУС үндэсний ажиллагаагаа өөрийн үндэсний онцлог, эрх зүйн тогтолцоо зэрэгт нийцүүлэн 3 үндсэн хэлбэрээр ажиллуулж байна.

Тухайлбал, 16 улс ЭШУС үндэсний ажиллагааны тухай хуулийн зохицуулалт болон бие даасан институт байдлаар байгуулсан байдаг бол 12 нь оршин буй хэд хэдэн механизмд чиг үүргийг хуваарилах буюу төрийн болон ТББ-

уудын хамтын оролцооны хэлбэрээр ЭШУС үндэсний ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хүний эрхийн байгууллагын дэргэд нэмэлт үүрэг оноох байдлаар 44 улс хэрэгжүүлж байгаа ч НҮБ-ын ЭШУС Дэд хорооноос бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулахыг зөвлөснөөр улс орнууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага /цаашид ҮУСБ/-аа байгуулсаар байна.

Энэ ч утгаар НҮБ-ын ЭШУС Дэд хорооноос Бразил, Холбооны бүгд найрамдах Герман, Тунис зэрэг улсын тэргүүн туршлагыг ЭШЭК-ын нэмэлт протоколд нэгдсэн улс оруудад зөвлөдөг байна. Үүнд:

- **Бразил Улс** нь ЭШУС, тэмцэх Үндэсний хороо, ЭШУС, тэмцэх Үндэсний механизм, Үндэсний хорих газар, Эрүүгийн болон хорих ангийн бодлогын Үндэсний зөвлөл, орон нутгийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хороодоос бүрдсэн ЭШУС, тэмцэх Үндэсний тогтолцоог байгуулж, чиг үүргийн хэрэгжилтээ хангадаг байна.⁶

Тус улс нь ЭШУС тэмцэх үндэсний тогтолцоог бүрдүүлэх; ЭШУС тэмцэх үндэсний хороо, ЭШУС тэмцэх үндэсний механизмыг бий болгох; бусад зохицуулалтыг хийх тухай

⁶<https://tbinternet.ohchr.org/>

12847 дугаар хууль”-ийг 2013 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Үндэсний Конгрессоос баталж, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.⁷

- **Холбооны Бүгд Найрамдах Герман Улс** нь ЭШУС үндэсний ажиллагаагаа хоёр бүтэцтэйгээр байгуулсан.

2008 оны 11 дүгээр сарын 20-нд ЭШУС үүрэг бүхий Холбооны агентлагаа, 2009 оны 6 сарын 25-ны өдөр Мужийн хамтарсан комиссоо байгуулжээ. Холбооны агентлаг нь ХБНГУ-ын харьяалалд хамаарах байгууламжууд, тухайлбал Холбооны цагдаа, Холбооны Зэвсэгт хүчин, Хилийн хяналт болон албадан буцаах нислэгт хяналт тавих үүрэгтэй бол Мужийн хамтарсан комисс нь гол төлөв мужуудын харьяалалд хамаарах шүүх, цагдаа, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагуудад хяналт шинжилгээ хийдэг.

Холбооны агентлаг болон Мужийн хамтарсан комисс нь ЭШУС чиг үүргийг хэрэгжүүлж, ЭШУС үндэсний тогтолцоог бүрдүүлэн хоорондоо нягт уялдаатай ажилладаг байна.⁸

Хамтарсан комиссын чиг үүрэг, бүрэн эрх нь 2009 оны 11 сарын 25-ны өдөр баталсан “Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулах тухай хууль”-аар зохицуулагддаг.⁹

- **Бүгд Найрамдах Тунис Улс** нь ЭШЭК-ын Нэмэлт протоколын 3 дугаар зүйлд заасны дагуу ЭШУС чиг үүрэг бүхий үндэсний ажиллагаагаа байгуулахдаа эрх зүйн бүрэн чадамжтай, захиргаа, санхүүгийн хувьд бие даасан, хараат бус байгууллага хэлбэрээр ЭШУС үндэсний газрыг байгуулжээ.

Үндэсний газар нь хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгэм, ТББ-ын төлөөллөөс 6, нийгмийн чиглэлээр мэргэшсэн 2, хууль, эрх зүйн их сургуулийн профессор, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн тус бүр 1, хууль эрх зүйн салбарын 2, эрүүл мэндийн салбарын 3, тэтгэвэрт гарсан шүүгч 2 гэсэн нийт 16 гишүүнээс бүрддэг.¹⁰

- **Бүгд Найрамдах Итали Улс** нь 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр ЭШЭК-ын Нэмэлт протоколд нэгдэн орсноос 2 жилийн дараа бие даасан үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагаа байгуулжээ. Уг байгууллага нь Коллежийн бүтэцтэй бөгөөд Ерөнхийлөгч, 2 гишүүнээс бүрддэг. Ажлын алба нь 25 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй. Нягтлан бодох бүртгэл, мэдээллийн технологи хариуцсан Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар; Цагдаагийн байгууллагын харьяа эрх чөлөөгөө хасуулах газрыг хариуцсан хэлтэс; ШШГ газрын харьяа эрх чөлөөгөө хасуулах газрыг хариуцсан хэлтэс, цагаач иргэдийн эрх чөлөөгөө хасуулах асуудал хариуцсан хэлтэс; эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд болон халамжийн газрыг хариуцсан хэлтэс; Коллежийг дэмжих хэлтэс; Судалгаа, Үндэсний болон олон улсын харилцааны хэлтэс гэсэн зохион байгуулалтаар чиг үүргээ хэрэгжүүлдэг.¹¹

- **Бүгд Найрамдах Киргиз Улс** нь үндэсний урьдчилан сэргийлэх бие даасан байгууллага байгуулсан Төв Азийн цөөн улсын нэг бөгөөд 2012 оны 07 дугаар сарын 12-ны өдөр “Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх үндэсний төвийн тухай” хуулийг¹² баталснаар эрх зүйн орчныг хангасан. Үндэсний төвийн удирдлага нь Зохицуулах зөвлөл бөгөөд Зохицуулалт,

⁷ L12847 (planalto.gov.br)

⁸ https://tbinternet.ohchr.org/_layouts/15/

⁹ Staatsvertrag_Laenderkommission.pdf (nationale-stelle.de)

¹⁰ https://tbinternet.ohchr.org/_layouts/15/

¹¹ National Guarantor of private freedoms - Office (garantenazionaleprivatiliberta.it)

¹² Zakon-O-NTSPP.pdf (npm.kg)

Аналитикийн хэлтэс, Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хэлтэс гэсэн зохион байгуулалттайгаар 7 мужийн салбарыг хамран чиг үүргээ хэрэгжүүлдэг.¹³

- **Бүгд Найрамдах Сенегал Улс** нь Африк тивээс ЭШЭК-ын Нэмэлт протоколд нэгдэн орсон улсуудын анхдагч улсуудын нэг бөгөөд 2006 оны 10 дугаар сарын 18-ны өдөр нэгдэн оржээ. 2009 оны 03 дугаар сард бие даасан үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага болох “Эрх чөлөөгөө хасуулсан газруудын үндэсний ажиглагч”-ийг байгуулсан. Үндэсний ажиглагч байгууллага нь байнгын 6 үндэсний ажиглагч, 5 хөндлөнгийн ажиглагч, захиргаа удирдлагын хэлтсийн 6 албан хаагч гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулдаг.¹⁴

- **Австралийн Холбооны Улс** нь 2017 оны 12 дугаар сард ЭШЭК-ын Нэмэлт протоколыг соёрхон баталсан боловч 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Нэмэлт протоколоор хүлээсэн үүргээ биелүүлж, Засан хүмүүжүүлэх газрын байцаагчийн алба, Хүний эрхийн Комисс, Омбудсман гэсэн 3 байгууллагын хамтарсан бүтцээр Хамтын нөхөрлөлийн үндэсний урьдчилан сэргийлэх ажиллагааг байгуулжээ. Цагаач иргэдийг саатуулах төв, Австралийн Холбооны Цагдаагийн байгууллага, Батлан хамгаалах хүчин зэрэг Хамтын нөхөрлөлийн харьяаны газруудад хяналт шалгалт хийдэг.¹⁵

Монгол Улс

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан билээ.

НҮБ-ын ЭШУС Дэд хороо Монгол Улсад 2017 онд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмжид дараах агуулга тусгагджээ.

“... ЭШУС Дэд хорооноос бие даасан, үр дүнтэй ҮУСМ-ыг бий болгохдоо ЭШУС Дэд хорооноос гаргасан Удирдамжид агуулагдах дараах элементүүдийг эрх бүхий байгууллагууд анхаарахыг зөвлөж байна. Үүнд:

(a) Нэмэлт протокол болон Парисын Зарчмуудад тусгагдсан холбогдох зүйл, заалтын дагуу үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох;

(b) ҮУСМ-д олгох эрх хэмжээ, бүрэн эрхийг хуульд тусгах, эсхүл үндсэн хуулийн үг хэллэгээр тодорхой илэрхийлэх, ҮУСМ-ын үйл ажиллагаа явуулах бие даасан, хараат бус байдлыг хуулиар баталгаажуулах, практикт хэрэгжүүлэх;

(c) ҮУСМ-ын гишүүд нь бие даасан, хараат бус байхын зэрэгцээ мэргэжлийн мэдлэг, тэр дундаа эрүүл мэндийн, сэтгэл зүйн болон өөрийн үүргийг үр дүнтэй гүйцэтгэх шаардлагатай бусад мэргэшсэн мэдлэг, чадварыг эзэмшсэн байх шаардлагатай.

(d) ҮУСМ нь Нэмэлт протоколын дагуу гүйцэтгэх өөрийн чиг үүргийг гүйцэтгэх чадна гэдгийг нягтлах хангалттай албан хаагчидтай байх ёстой, мөн өөрийн эрх хэмжээний хүрээнд цагдах хорих төвүүдийн тоотой харьцуулж үйл ажиллагаа явуулах чадвартай байх шаардлагатай.

(e) ҮУСМ үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад шаардагдах нөөцөөр хангагдахыг зөвшөөрөх ёстой. Нэмэлт протоколын дагуу чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж санхүүгийн болон үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлаар бүрэн хангагдах шаардлагатай. ҮУСМ-ын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад, бусад байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг гаргахад нөөцийг жилийн

¹³ National legislation - NPM

¹⁴ Referral to the National Observer | ONLPL

¹⁵ [About us | Commonwealth Ombudsman](#)

төсөвт тусгайлан нэг нэгж болгон оруулж, урьдчилан тооцоолох замаар баталгаажуулна.

(f) ҮҮСМ нь Монгол Улсад хангалттай үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа боловч одоогоор оршин байгаа системийг өөрчлөн орлохоос илүүтэй багийн системийг дэмжин, бие биеэ нөхөн хамтран ажиллах, бусад нэмэлт системийг ажиллуулах бололцоог хаахгүй байх;

(g) Оролцогч улс ҮҮСМ-аас тодорхойлсон хугацаанд уулзалтуудыг зохион байгуулах боломжоор тус механизмыг хангах шаардлагатай. Үүнд эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүстэй хувийн ярилцлага хийх, мөн Нэмэлт протоколд заасны дагуу эрх чөлөөг хязгаарлаж буй газруудад хэдийд ч урьдчилан мэдэгдэлгүй очих эрх орно.

(h) Бусад байгууллагууд болон олон нийтийн зүгээс ҮҮСМ-ыг эрүү шүүлтийн эсрэг голлох үүрэг гүйцэтгэдэг байгууллага мөн гэсэн ойлголттой байх ёстой. Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд урьдчилан сэргийлэх механизмд олгож байгаа бүрэн эрхийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, энэ талаар сурталчлах нь ач холбогдолтой гэдгийг ЭШУС Дэд хорооноос онцлон сануулж байгаа бөгөөд үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг тус улсын системд байгаа эрүү шүүлтээс хамгаалах гол бүрэлдэхүүн хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай.”

ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл¹⁶-д ЭШУС асуудлаар ЭШЭК-ын Нэмэлт протоколд заасны дагуу ЭШУС үндэсний байгууллагыг нэн даруй байгуулах саналыг гаргаж байсан.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийг шинэчлэн батлахдаа ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний бүрэн эрх, чиг үүрэг, ЭШУС үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгасан.

Энэ ч утгаар НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд Монгол Улсаас конвенцын хэрэгжилтийн талаар хүргүүлэх ээлжит гурав дахь удаагийн тайлан /2020/¹⁷-д дараах биелэлтийг тайлагнаж дүгнэсэн байна. Үүнд:

“ 148. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох талаар тусгасан....., ...

150. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хууль батлагдсанаар Парисын зарчмуудын дагуу үйл ажиллагааг хараат бусаар, үр дүнтэй явуулах эрх хэмжээ бүхий хангалттай хүний нөөцөөр хангагдах эрх зүйн үндэслэл бий болсон. ...

155. Эрүү шүүлтийн эсрэг үндэсний механизмыг бий болгож, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаа явуулах гишүүн, нэгжийн чиг үүргийг дээрх хуульд тусгасан. Тус нэгжид 1 удирдах ажилтан буюу комиссараас гадна гүйцэтгэх 7 албан хаагч, үйлчлэх 3 ажилтны орон тоог баталсан.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийг хэрэгжүүлэх тэр дундаа ЭШУС үндэсний ажиллагааг үр дүнтэй ажиллуулахтай холбогдох зардлыг 339,134,850 төгрөг /ойролцоогоор 119,011,80 ам. доллар/-ийг 2021 оны улсын төсөвт тусгасан. Иймд санхүүгийн хувьд үйл ажиллагаа явуулах нөхцөл хангагдсан болно.” ДҮГНЭЛТ

415. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн ХЭҮК-ын бүтцэд бий болгох эрх зүйн үндсийг тавьсан нь тус улсад ЭШУС бие даасан, хараат бус механизм бий болох эрх зүйн орчныг бүрдүүллээ.

¹⁶ <https://nhrcm.gov.mn>

¹⁷ Хүний эрхийн Үндэсний Комисс, НҮБ-ын Монгол Улс дахь Суурин зохицуулагчийн газар “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс эмхэтгэл”, 2021 он, УБ Хоёрдугаар боть, 457 дахь тал

416. Монгол Улсын Засгийн газар ЭШЭК-ын дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах тал дээр хүчин чармайлт гаргаж байгаа болно.”.

Монгол Улс ЭШЭК-д нэгдэн орохдоо 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийгээгүй тул манай улсын иргэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд ШЭХ-нд хандан гомдол гаргах боломж хаалттай учраас ЭШЭК-ын хувь хүний, улс хоорондын гомдол, мэдээллийн журмыг хүлээн зөвшөөрөх мэдэгдэл хүргүүлэх¹⁸ тухай саналыг судлаач, эрүү шүүлтийн хохирогчид гаргаж байна.

1.2. ЭШУС үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 3 дугаар зүйлд хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно гэж тайлбарласан. Үүнд:

- "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс" гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллагыг;
- "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх" гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг”

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 12 дугаар зүйлд 12.1 дэх хэсэгт “Комисс зургаан гишүүнтэй байна.” гэж заасан бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь хуулийн үзэл баримтлал, нэр томъёоны агуулгаар Комиссын гишүүн бус байна.

Тухайлбал, энэхүү хуулийн Наймдугаар бүлгийн нэршлийг Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн баталгаа гэж томъёолжээ.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан 16.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 7.1-д заасан Комиссын чиг үүрэгт хамаарах дараах асуудлыг Комиссын хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.” гэж заасан бөгөөд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаатай холбоотой асуудал тусгагдаагүй нь ЭШУС үндэсний ажиллагааны хараат бус байдал төдийгүй ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь ХЭҮК-ын гишүүний чиг үүргээс тусдаа гэдгийг сануулж буй хэрэг юм.¹⁹

Түүнчлэн Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.10 дахь заалтаар Комиссын даргад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх” үүргийг хүлээлгэжээ.

1.2.1. ЭШУС нэгжийн хүний нөөцийн асуудлаар

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн томилогдсон.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон

¹⁸ “Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцаанаас анги байх эрхийн хэрэгжилт” (Монгол Улсын Хүний эрхийн ТББ-уудын форум, 2019.10.03).

¹⁹ Нээлттэй нийгэм форум “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон нэгжид зориулсан гарын авлага, УБ, 2021, 30 дахь тал

тооны нэгж ажиллана.”, ...зөвхөн энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн хүрээнд хүний нөөцийн асуудлаа 10 албан хаагчтай ажиллахаар зохион байгуулж, ТАЗ-ийн 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар “Албан тушаалын тодорхойлолт”-уудыг батлуулсан.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн Б/01 дүгээр тушаалаар ЭШУС хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч²⁰, Комиссын Тамгын газрын даргын мөн өдрийн Б/50 дугаар тушаалаар тус хэлтсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч²¹, Б/51 дүгээр тушаалаар Тогтоол шийдвэр, бүртгэл мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн²² тус тус томилогдон 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлэв.

Комиссын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн Б/80 дугаар тушаалаар ЭШУС хэлтсийн хэвлэл мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч томилогдож ЭШУС хэлтэс 4 хүний нөөцтэйгөөр хуульд заасан үүргээ биелүүлж эхлэв.

ТАЗ-ийн тогтоол болон хуульд заасан журмын дагуу Комиссын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/04 дугаар тушаалаар ЭШУС хэлтсийн хэвлэл, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн томилогдсон.

Комиссын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/ дугаар тушаалаар мөн хэлтсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ТАЗ-ийн шалгалтад оролцож байгаа процесст нь чөлөөлсөн.

ЭШУС хэлтэс нь хэдийгээр ТАЗ-өөс 10 албан хаагчтай байх “Албан тушаалын тодорхойлолт”-ыг баталсан боловч, Ковид 19 цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилгоор Төрийн хэмнэлтийн хуулийг батлан хэрэгжүүлж байгаа нөхцөл байдлаас үүдэн төсвийн хангалттай бус байдалд 2023 оны 03 дугаар сарын 15-ны байдлаар 4 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэж хуульчилсан.

2020 оны Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулиар ЭШУС үндэсний ажиллагаа эдийн засгийн хувьд хараат бус хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна. Жишээлбэл, Сангийн яам ЭШУС үндэсний үйл ажиллагааны 2022-2023 оны төсвийг /нийт 11 орон тоо, цалингийн сан батлагдсан байснаас/ 5 орон тоо, цалингийн санг хасаж, үйл ажиллагааны урсгал зардлыг бууруулж УИХ-д оруулж баталсан.

2022 онд Хүний эрхийн Үндэсний Комиссыг улсын төсвөөс 2,739,911,100.00 мянган төгрөг санхүүжүүлж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүнд туслах чиг үүрэг бүхий нэгж

²⁰ Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 06/316 дугаар тогтоол болон холбогдох хууль, журмыг үндэслэн ЭШУСА эрхэлсэн гишүүний 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн Б/01 дүгээр тушаалаар ЭШУС хэлтсийн дарга томилогдсон.

²¹ Комиссын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/50 дугаар тушаалаар тус хэлтсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлсөн байна.

²² ТАЗ-ийн 03 дугаар сарын 14-ний өдрийн 85 дугаар тогтоол болон холбогдох хууль, журмыг үндэслэн Комиссын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Б/41 дүгээр тушаалаар ЭШУС хэлтсийн сургалт хариуцсан референт, мөн өдрийн Б/46 тушаалаар хэлтсийн хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдсон.

166,241,268.71 мянган төгрөгийг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд хууль тогтоомжийн дагуу зарцуулагдсан.

2023 онд Хүний эрхийн Үндэсний Комисст улсын төсвөөс 4,480,547.10 мянган төгрөг санхүүжүүлэх бөгөөд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүнд туслах чиг үүрэг бүхий нэгжид 439,976.02 мянган төгрөг төсөвлөгдсөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

1.2.2. Хүний нөөцийн мэргэшсэн байдал, чадавхжуулах талаар

Хэлтэс нь эрх зүйч, сэтгэл зүйч, сэтгүүлч мэргэжилтэй, хууль эрх зүйн чиглэлийн удирдах болон багшлах олон жилийн туршлага хуримтлуулсан, хүний эрх хамгаалал, нийгмийн эмзэг бүлгийнхэнтэй ажиллаж байсан ур чадвар, мэргэшил, туршлагатай албан хаагчдаар бүрэлдэхүүнээ бүрдүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Төрийн албаны хууль тогтоомжид заасан шалгуур, шаардлага болон ЭШЭК-ын Нэмэлт протоколд заасан албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадавхыг дээшлүүлэх зорилгоор ЭШУС хэлтсийн албан хаагчдыг холбогдох сургалт, хөтөлбөрүүдэд идэвхтэй хамруулж байна.²³ Үүнд:

- ЗГ-ын хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академийн төрийн албаны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хэлтсийн 3 алба хаагч хамрагдан амжилттай төгссөн.

- ХЭҮК-т шинээр томилогдсон албан хаагчдын чиглүүлэх сургалтууд

- “Ёслол-Байгууллагын гадаад харилцаа”, “Хүний эрхийн үндэсний байгууллага ба олон улсын механизм, хамтын нийгэмлэг”, “Ази Номхон далайн чуулганы гишүүн байгууллагуудын сүлжээнүүдийн үйл ажиллагаа” сэдэвт Хүний эрхийн Үндэсний байгууллагын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоо, хамтын ажиллагаа, төрийн байгууллагын гадаад харилцаа, ёслолын сургалт

- “Эрүү шүүлтийн эсрэг санаачилга”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг”, “Норвегийн хүний эрхийн төв” олон улсын байгууллагуудын хамтран боловсруулсан “Мэдээлэл цуглуулах, мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ын агуулга, үзэл баримтлал, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагын талаар танилцуулга-сургалт

- “Монголын Эмнести Интернэшнл” ОУБ-ын боловсруулсан “Хорих, цагдан хорих газарт хийх мониторинг” гарын авлага дээр үндэслэн хяналт шинжилгээг хүний эрхийн стандартад нийцүүлэн явуулах сургалт

- “Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц” сэдэвт сургалт

Түүнчлэн ЭШУС ажиллагаа, хяналт шинжилгээний хүрээнд хэрэглэгдэх Монгол Улсын хууль, эрх зүйн талаар системчилсэн сургалтад албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн болон ЭХХШТ хууль, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ШШГТ хууль гэх мэт.

²³ ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн гүйцэтгэлийн тайлангаас

**ХОЁР. ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ, ХУУЛЬ БУСААР БАРИВЧЛАХ, ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАХ ГЭМТ ХЭРГҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ, СТАТИСТИКТ
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

2.1. Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг харьцуулбал:	
2002 оны Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл	2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл
251.1.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
251.2.Энэ хэргийн улмаас хүний бие махбодод хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасаж таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ	
251.3. Энэ хэргийн улмаас хохирогч нас барсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	
Тайлбар: 2015 оны Эрүүгийн хуулиар энэ гэмт хэргийн улмаас хүний бие махбодод хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан эсхүл хохирогч нас барсан тохиолдолд гэм буруугаас шалтгаалан Эрүүгийн хуульд заасан хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учруулах, эсхүл амь насыг хохироох, алах гэмт хэргээр давхар зүйлчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.	

“Эрүүдэн шүүх” үйлдлийг Эрүүгийн хуульд 4 төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд оруулсан нь гэмт хэргийн зүйлчлэлд тодорхойгүй байдлыг үүсгэж байгаа тул Конвенцын дагуу “эрүүдэн шүүх” гэмт хэргийг оновчтой тодорхойлж, ялыг чангатгах саналыг судлаачид гаргасан байна.²⁴

Түүнчлэн 2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлийн агуулга нь ЭШЭК-ийн 1 дүгээр зүйлд “эрүү шүүлт гэж ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь

²⁴ “Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцаанаас ангид байх эрхийн хэрэгжилт” (Монгол Улсын Хүний эрхийн ТББ-уудын форум, 2019.10.03).

этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдэл” гэснийг бүрэн агуулаагүй байна.

Иймд эрүү шүүлт тулгах эсхүл гутаан доромжлох, шахалт дарамт үзүүлэх сэдэлт, зорилго нь гуравдагч хүн ч эрүүгийн хариуцлага хүлээхээр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14-т Монгол Улсын иргэн “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ гэж заасан. ЭШЭК-ын 14.1-т “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй.” гэж заасан.

Гэтэл, шүүх эрүү шүүлтийн хохирлыг тэр бүр “бодитой” арилгадаггүй, ялангуяа эдийн бус гэм хорд шударга нөхөн төлбөр өгдөггүй²⁵ тул эрүү шүүлтэд өртсөн болон бусад хохирогч эдийн болон эдийн бус гэм хороо нөхөн төлүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Тохиолдол

...11 жил эрүүгийн хэрэгт шалгагдахдаа 274 хоног цагдан хоригдож, 3 сар хорих ял эдэлж, учирсан хохирлоо иргэний хэргийн шүүхээр төлүүлэхээр шийдвэрлүүлтэл буцаагаад зарим эрүүгийн хэргийг сэргээн шалгаж улмаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон....ингээд холбогдох мөрдөгч, прокурор, шүүгчид холбогдуулан гаргасан гомдлыг шүүх, прокурор нь шалгахгүй хаацайлж, тэдгээрийн хүнд суртал, чирэгдлээс шалтгаалан өнөөг болтол 20 жил төрийн байгууллагын хаалга татаж явна. Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний зөрчигдсөн эрх, эрх чөлөөг сэргээхээр бүхий л газарт хандахад буцаагаад л прокурорт нь шилжүүлээд өмнөх хариу нь ирэх юм. ... Иймд УИХ-ын хяналт шалгалтын тухай хуульд зааснаар гомдлоо гаргасан байгаа...

(Ц.Г- той хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Нөгөөтээгүүр 2014 онд УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албыг татан буулгаснаас хойш мөрдөн шалгалт ашиг сонирхлын зөрчилтэй, үр дүнгүй болж, эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх байдал ноцтой буурсан гэж НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, НҮБ-ын гэрээний хороод, ХЭҮК, Монгол Улсын Хүний эрхийн ТББ-уудын форум нэгэн дуугаар дүгнэдэг байна.²⁶

ЭХХШТ хуулиар эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байхаар хатуу зохицуулаагүй байх тул нотлох баримтаар тооцохыг хориглох

²⁵ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 14 дэх илтгэл (ХЭҮК, 2015), 24; Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 19 дэх илтгэл (ХЭҮК, 2020), 162-166.

²⁶“НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр бусад улсаас өгсөн зөвлөмж” (2020), §4, 49, 51, 52, 53, 54, 55; “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит зургаа дахь илтгэлийг хэлэлцээд гаргасан Хүний эрхийн хорооны дүгнэлт” (2017), §21; “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсад өгсөн зөвлөмж” (2016), §15; “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 сарын 11-нээс 20-ны өдрүүдэд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмжүүд” (2017), §26-29; Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 18 дахь илтгэл (ХЭҮК, 2019) 150; “Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцаанаас ангид байх эрхийн хэрэгжилт” (Монгол Улсын Хүний эрхийн ТББ-уудын форум, 2019.10.03).

заалтыг энэхүү хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулах замаар тусгах санал өмгөөлөгчид, судлаачдаас ирүүлж байна.

2.2. Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн тухай гомдол мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн статистик

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “... Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагаас гаргуулах болон бусад хэлбэрээр хамтран ажиллана.”, 34 дүгээр зүйлд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн энэ зүйлийн 34.1.7 дахь заалт “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашгийн төлөө бус хуулийн этгээд болон бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох...; бүрэн эрхийг хуульчилсны дагуу холбогдох байгууллага албан тушаалтнаас мэдээллүүдийг гаргуулан авч дүн шинжилгээ хийн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл²⁷д “... Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/67, 2020 оны А/33 дугаар тушаалаар цагдаа, тагнуулын байгууллагын алба хаагчийн албан ажлын байранд үйлдсэн эрүүдэн шүүсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг АТГ мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар тусгаж өгсөн тул гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл гаргах боломжгүй байна, ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газраас 2017-2023 онд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдаас эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхахтай холбоотой 7 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн шалгаснаас алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй 6, АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст 1 гомдлыг харъяаллын дагуу шалгуулахаар шилжүүлж, шийдвэрлэсэн ..., ЭШУС чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын жагсаалт байхгүй...” талаар тус тус дурдсан.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн Ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр бусад улсаас “... эрүү шүүлт, тэр дундаа эрх чөлөөг нь хассан хүнийг эрүүдэн шүүсэнтэй холбоотой гомдлыг шалган шийдвэрлэх бие даасан, үр дүнтэй процедур бий болгох (Мексик, Франц Польш, Румын); ... Эрүүдэн шүүх, хүний нэр төрийг гутаан доромжилсон хэргийг мөрдөн шалгах бие даасан байгууллага байгуулах (Мальдив, Ботсвана, Испани);...зөвлөмж²⁸-ийг ирүүлсэн байна.

²⁷ ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны дэд даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 9/1-888 дугаартай албан бичгүүдээр ирүүлсэн мэдээллээс

²⁸ ²⁸ <https://www.upr-mongolia.mn/?cmd=Content&menuid=41&id=227>. 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг механизмаар 3 дахь удаа хэлэлцээд 170 зөвлөмж өглөө.




Харин прокурорын мэдээлэлд²⁹ 2017 оны сүүлийн хагас жил, 2018-2022 оны байдлаар улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 13.9 /Хууль бусаар баривчлах/, 14.1 /Ялгаварлан гадуурхах/, 21.12 /Эрүү шүүлт тулгах/ гэмт хэргүүдэд нийт 385 гомдол, мэдээлэл бүртгэгдэн 471 хүн шалгагдсанаас 359 гомдол, мэдээлэл буюу 93,2 %, 449 хүн буюу 95,3 % нь тус тус цагдаагийн алба хаагчтай

холбоотой байна.

ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс эрүү шүүлт тулгах гэмт хэргийг 2017, 2018 онд хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг ХЭҮК тухайн үед авахад Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017, 2018 онд 2002 оны Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл, 2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/-ээр хэрэг хянан шийдвэрлэгдээгүй байна.³⁰

Цагдаагийн алба хаагчдад холбогдуулан 2017 оны хагас жилийн байдлаар 5 гомдол, мэдээлэлд 5, 2018 онд 33 гомдол, мэдээлэлд 47, 2019 онд 74 гомдол, мэдээлэлд 96, 2020 онд 86 гомдол, мэдээлэлд 115, 2021 онд 86 гомдол, мэдээлэлд 99, 2022 онд 75 гомдол, мэдээлэлд 87 алба хаагч тус бүрт дээрхи гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг иргэн, албан тушаалтнаас гаргажээ.




2017 оны сүүлийн хагас жилийн байдлаар 6 хэрэг бүртгэлтийн хэрэгт 9, 2018 онд 28 хэрэг бүртгэлтийн хэрэгт 33, 2019 онд 46 хэрэг бүртгэлтийн хэрэгт 55, 2020 онд 51 хэрэг бүртгэлтийн хэрэгт 67, 2021 онд 26 хэрэг бүртгэлтийн хэрэгт 35, 2022 онд 22 хэрэг бүртгэлтийн хэрэгт 27 цагдаагийн алба хаагч шалгагджээ.

²⁹ УЕП-ын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 4/1751,

³⁰ ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 04/259 дугаар албан бичгээс

Прокурорын байгууллагаас 2018 онд 1 хүнтэй 1, 2020 онд 1 хүнтэй 1, 2021 онд 3 хүнтэй 2, 2022 онд 2 хүнтэй 1 эрүүгийн хэргийг тус тус хэрэгсэхгүй болгосны зэрэгцээ 2018, 2019 онд тус бүр 1 хүнтэй 1, 2020 онд 7 хүнтэй 4, 2021 онд 4 хүнтэй 2, 2022 онд 7 хүнтэй 5 эрүүгийн хэргүүдэд яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн байх бөгөөд 2022 онд өмнөх оноос 2,5 дахин өсжээ.



2016-2023 оны 03 дүгээр сар хүртэл Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний халдашгүй байх эрхтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний комисст иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээллийн статистик³¹

Статистикт тусгагдсан хууль бусаар баривчлах, хууль бусаар цагдан хоригдсон мэдээлэл нь ЭШЭК-оор эрүү шүүлтийн тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдэл бөгөөд тэдгээрийг нэгтгэн дүгнэвэл зохистой байна.

Эрхийн төрлөөр	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023. 02.28	Бүгд
Эрүү шүүлтээс ангид байх	40	25	40	28	47	27	15	3	225
Хууль бусаар баривчлах	1	1	11	21	8	10	11	0	63
Хууль бусаар цагдан хорих	38	20	51	56	21	44	85	6	321
Гэр бүл, захидал харилцаа	2	7	13	3	1	7	6	0	39
Нэр төрийн халдашгүй байдал	16	11	15	20	25	47	44	0	178
Орон байрны халдашгүй байдал	1	1	3	6	3	7	5	3	29



2016 оноос 2023 оны 03 дугаар сар хүртэлх хугацаанд Хүний эрхийн Үндэсний комисст эрүү шүүлтээс ангид байх 225, хууль бусаар баривчлах 63, хууль бусаар цагдан хорих 321 буюу нийт 609 гомдлыг иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн.

³¹ Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, мэдээлэл шалгах хэлтсийн мэдээллээс...

Энэхүү статистикийн шийдвэрлэлт дараах агуулгатай байна.Үүнд:

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуульд зааснаар гомдлыг шийдвэрлэхээс татгалзсан
- Гомдол гаргагч гомдлоосоо татгалзах
- Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг ЭХХШТ хуульд заасны дагуу харъяаллын дагуу шилжүүлэх
- Холбогдох шалгалтын ажиллагааг явуулж зохих байгууллагад Комиссын гишүүний зөвлөмж, шаардлага хүргүүлэх

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Комисс мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, маргааны талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахгүй.” гэж заасан байна.

ГУРАВ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

НҮБ-ын ЭШУС Дэд хороо Монгол Улсад 2017 онд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмж -д ... (g) Оролцогч улс үндэсний урьдчилан сэргийлэх механизмаас тодорхойлсон хугацаанд уулзалтуудыг зохион байгуулах боломжоор тус механизмыг хангах шаардлагатай. Үүнд эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүстэй хувийн ярилцлага хийх, мөн Нэмэлт протоколд заасны дагуу эрх чөлөөг хязгаарлаж буй газруудад хэдийд ч урьдчилан мэдэгдэлгүй очих эрх орно.” гэж заасан.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 34 дүгээр зүйлд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь энэ зүйлийн 34.1.1 дэх заалтаар “энэ хуулийн 33.1.1-д заасан газарт аль ч цаг үед саадгүй нэвтрэх, хяналт шинжилгээ хийх;”, 34.1.3 дахь заалт “энэ хуулийн 33.1.1-д заасан газар, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүний талаарх бүх төрлийн мэдээллийг аль ч үед гаргуулан авах;” бүрэн эрх баталгаажсан байна.

Хяналт, шинжилгээний хүрээнд НҮБ-ын ЭШУС Дэд хорооноос гаргасан жишиг хяналт шинжилгээ хийх аргачлалын дагуу тус байрны нөхцөл байдалтай танилцаж, удирдлагын баг, ажилтан албан хаагчид, харуул, хамгаалалтын алба хаагч, бусад эрх чөлөө нь хязгаарлагдсан хүнтэй биечлэн уулзаж, амаар болон бичгээр тайлбар авах, ярилцлага хийх, дуу, дүрсний болон техник хэрэгсэл ашиглан холбогдох бичиг баримтыг гаргуулах авч, газар дээр нь танилцах, баримтжуулан хуулбарлан авч хууль тогтоомж, баримт бичгийн дүн шинжилгээ хийн ажилласан болно.

Хяналт шинжилгээний хүрээнд нийт 1,954 хүнээс асуумж авч, 202 эрх чөлөө нь хязгаарлагдсан хүн, 48 ажилтан, алба хаагч нартай ганцаарчилсан ярилцлага хийж, тэдгээрээс гаргасан зарим санал, хүсэлтийг эрх бүхий албан тушаалтнаар даруй шийдвэрлүүлэн ажиллажээ.

3.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийгдсэн хяналт шинжилгээ

ШШГ байгууллага нь Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм”-ийн дагуу хаалттай 5, нээлттэй 7, нээлттэй, хаалттай дэглэмтэй 5 хорих анги, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага 1, эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1 буюу нийт 21 хорих анги, Баривчлах төв, байр тус бүр 1, Нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 28 цагдан хорих байртайгаар ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох хууль, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Баривчлах зохицуулалтыг хэрэгжүүлж буй талаарх мэдээлэл³²

№	Асуулт		2020 он	2021 он	2022 он
1	Нийт баривчлагдсан сэжигтний тоо		798	821	1075
2	Үүнээс	Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдсан	793	809	1072
3		Шүүхийн зөвшөөрлөөр баривчлагдсан	5	12	3
4	Тогтоолыг 24 цагийн дотор шүүхэд хүргүүлж, 48 цаг хүртэлх хугацаагаар баривчлагдсан сэжигтэн		330	347	599

³² ХЭҮК-ын гишүүн Б.Энхболдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06/159 дугаартай албан бичигт хариу өгсөн Улсын ерөнхий прокурорын газрын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 4/1750 дугаартай албан бичгийн хавсралтаас

5	Тогтоолыг шүүхэд хүргүүлэхгүйгээр 48 цагийн хугацаагаар баривчлагдсан сэжигтэн	398	334	355
6	Баривчлагдсан сэжигтнээс үргэлжлүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан	448	496	595
7	Баривчлагдсан сэжигтнээс шүүхийн шийдвэрээр суллагдсан	117	72	220
8	Баривчлагдсан сэжигтнээс прокурорын шийдвэрээр суллагдсан	214	224	232

Шүүхийн өмнөх шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэсэн талаар³³

№	Асуулт	2020 он	2021 он	2022 он
1	Нийт шалгагдсан эрүүгийн хэргийн тоо	21041	21242	26149
2	Үүнээс яллагдагч нарын тоо	19959	18486	20608
3	Үүнээс өсвөр насны яллагдагч нарын тоо	1076	966	1326
4	Мөрдөх албадаас прокурорт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах санал ирүүлсэн	1561	1298	1732
5	Прокурор саналыг хүлээн авч шүүхэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах санал хүргүүлсэн	1499	1294	1712
6	Шүүхээс прокурорын саналыг хүлээн авахаас татгалзсан	161	148	176
7	Шүүхээс прокурорын саналыг хүлээн авч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэсэн	1867	1454	1561

ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, баривчлах байр, Говь-сүмбэр аймаг дахь ШШГ газрын 425 дугаар нээлттэй хорих анги, Төв аймгийн Баян сумын ШШГ газрын 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Дундговь, Өмнөговь аймаг дахь ШШГ газрын цагдан хорих байрууд, баривчлах байрууд, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай аймаг дахь ШШГ газрын цагдан хорих байр, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГ хэлтсийн 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, СЭМҮТ-ийн ШСЭСК, газар орон, байршилд батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ хийсэн байна.

Цагдан хорих төвүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээ, шударга ёсны тогтолцоог бий болгох, цагдаагийн үйл ажиллагааг удирдлагаар хангах бүх үүрэг хариуцлага ХЗДХЯ-нд оногдсон байна гэж НҮБ-ын ЭШУС Дэд хороо дүгнэжээ. “Энэ нь сонирхлын ноцтой зөрчилд хүргэж болох бөгөөд урьдчилан сэргийлэх ойлголтын үүднээс авч үзвэл оновчгүй, эрх мэдлийн хуваарилалтын эсрэг чиглэсэн, цагдан хорих систем болон эрүүгийн шударга ёсны тогтолцоог үр дүнтэй удирдахад хохирол учруулж болзошгүй юм.”³⁴

НҮБ-ын ЭШУС Дэд хорооны зөвлөснөөр цагдаагийн үйл ажиллагааг удирдлагаар хангах болон шударга ёсны тогтолцоог бий болгох үүргийг тус тусдаа яаманд хариуцуулах, цагдан хорих, саатуулах газарт үзүүлж байгаа эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүргийг ЭМЯ-нд шилжүүлэх саналыг судлаачид гаргасныг судлах нь зүйтэй байна.³⁵


³³ ХЭҮК-ын гишүүн Б.Энхболдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06/159 дугаартай албан бичигт хариу өгсөн Улсын ерөнхий прокурорын газрын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 4/1750 дугаартай албан бичгийн хавсралтаас

³⁴ “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 сарын 11-ээс 20-ны өдрүүдэд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмжүүд” (2017), §23-24, 91.

³⁵ Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл /тойм судалгаа/ Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэн 2021, УБ., 31 дэх тал.

Хяналт шинжилгээний хүрээнд хорих ангийн алба хаагчдад хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтын талаар сургалт, мэдээллийг өгч зарим алба хаагчидтай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг явуулснаас гадна 246 алба хаагчдаас “Албан үүргээ гүйцэтгэхэд гардаг хүндрэл бэрхшээл”-ийн талаар асуумж авахад дараах агуулгаар хариулжээ. Үүнд:

- Асуулт 1. Амралтын болон баяр ёслолын үеэр амардаггүй, ажлын илүү цаг, нөхөн олговор авдаггүй гэж 79.6%;
- Асуулт 2. Олон цагаар ажилладаг гэж 42%;
- Асуулт 3. Ээлжийн амралтаа биечлэн эдэлж чаддаггүй гэж 18%;
- Асуулт 4. Удирдлагын арга барил, ажлын зохион байгуулалт муу гэж 26% ;
- Асуулт 5. Мэдлэг боловсролоо байнга дээшлүүлэх боломжгүй гэж 12.1%
- Асуулт 6. Удирдлага болон хамт ажиллагсад, хоригдлуудын зүгээс хэл амаар доромжлох, гүтгэх, ялгаварлан гадуурхдаг гэж 21.1%;
- Асуулт 7. Мэргэжлээс шалтгаалах өвчин туссан гэж 8.1%;
- Асуулт 8. Халдлагад өртөх, эрүүл мэндээрээ хохирсон гэж 20.3%;
- Асуулт 9. Удирдлагаас хуульд заагаагүй ажил үүрэг гүйцэтгүүлдэг гэж 18.2%;
- Асуулт 10. Ажлын байрны бэлгийн дарамт, ялгаварлан гадуурхалтад өртсөн гэж 2.8%;
- Асуулт 11. Удирдах албан тушаалтнаас бэлгийн дарамт учруулсан гэж 0.4%.



Тохиолдол

“ ... ангийн удирдах албан тушаалтнуудаас ажлын байран дээр байнга бүдүүлэг үг, хэллэг хэрэглэдэг ... ажлын байрны дарамт үзүүлж, ялгаварлан гадуурхдаг ... энэ байдлаас үүдэн байнгын сэтгэл санааны зовнил, хямралтай байдаг,” алба хаагчдын эрх зүйн байдал, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний асуудалд илүү их анхаарах шаардлагатай байгаа.....

(Хорих ангийн алба хаагчтай ганцаарчлан ярилцсан тэмдэглэлээс)

Иймд НҮБ-ын хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдийн 46.1 дэх хэсэгт “ШШГЕГ-ын удирдлага нь бүх төрлийн хүний нөөцөө онцгой нягтлан сонгоход санаа тавих ёстой бөгөөд тэдний хариуцлага, хүнлэг байдал, хувийн чанараас нь үйл ажиллагаа сайн байх эсэх ихээхэн хамаарна.” гэж заасан байна.

Түүнчлэн Баривчлах байрны 17 алба хаагчидтай ганцаарчилсан уулзалт хийж, асуумж авахад доорх байдлаар дүгнэснийг үйл ажиллагаандаа анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- “Баривчлагдсан хүнтэй хэрхэн харьцах талаар сургалтад хамрагддаг эсэх?” гэсэн асуултад 35.7% нь үгүй,

- “Монгол хэл, бичиг мэддэггүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнд дотоод журам, цагийн хуваарь, сахилгын шийтгэл ногдуулах журам, эрх, үүргийг тайлбарлахад бэрхшээл тулгардаг уу?” гэсэн асуултад 27.3% нь тийм,

- “Таны ажлын илүү цаг, долоо хоногийн амралтын болон баяр ёслолын үеэр нөхөн амарч чадаж байгаа эсэх? Нөхөн олговор авдаг эсэх?” гэсэн асуултад 69.2% нь үгүй,

- “Та ээлжийн амралтаа биечлэн эдэлж чаддаг уу? Үгүй бол яагаад?” гэсэн асуултад 30.8% нь хүн хүч хүрэлцдэггүй учраас дуудагддаг, амралтын хугацаанаас өмнө дуудаж оруулдаг, орон тоо дутуу учраас дуудаж оруулдаг учраас үгүй гэж.

Алба хаагчид орон тоо дутуугаас илүү цагаар ажиллах, удирдлагын арга барил, ажлын зохион байгуулалт, мэдлэг боловсролоо байнга дээшлүүлэх боломжгүй байдалд шүүмжлэлтэй хандаж, бусдын халдлагад өртөх, эрүүл мэндээрээ хохирох ялангуяа баривчлагдсан хүний зүгээс хэл амаар доромжлох, эсэргүүцэх, заналхийлэх эрсдэлтэй байдалд ажилладаг талаар дурдсан.

Тухайлбал, алба хаагч асуумжид “... 08:30-21:30 хүртэл сүүлийн саруудад амралтын нэг ч өдөр амраахгүй ажиллуулж байна. ... үр хүүхдэдээ анхаарал тавимаар байна гэхэд зарим удирдлага...хүн хүч дутмаг байна...дээрээс шийдэж өгөхгүй байна. ...цэргийн байгууллага өргөдлөө өгөөд зайл, ажлаас гар гэж байнга дарамталдаг...” гэж бичжээ.

Мөн алба хаагчаас ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн талаар дурдаж энэ талаар зохих байгууллага албан тушаалтанд мэдэгдээгүй байгаа талаар бичжээ.

ШШГ байгууллагын алба хаагчийн хүний нөөцийн дутагдал нь ажилласан жилийн болзол хангаснаар Цэргийн албаны тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар тэтгэвэр тогтоолгон чөлөөлөгдөж байгаатай холбоотой төдийгүй дараах нөхцөл байдлаас шалтгаалан албанаас халагдах, чөлөөлөгдөх эсхүл энэхүү мэргэжлийг сонгодоггүйгээс харуул хамгаалалт, жижүүрийн үүргийг 24/48 цагаар 3 ээлжээр, бусад алба хаагчид илүү цагаар үүрэг гүйцэтгэж байна. Үүнд:

- Цалин хөлс нь нийгмийг баталгааг хангах бололцоогүй байдал;

- Албан үүргээ гүйцэтгэх явцдаа буруутгагдах буюу ялангуяа эрүүгийн хариуцлага хүлээх эрсдэлтэй өндөртэй төдийгүй алба хаагчдын хууль ёсны эрх, ашиг зөрчигддөг;

- Ажлын ачаалал их, стресстэй байдал;

- Бусад.

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлд заасан “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах ...”, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... цалин хөлс авах, амрах...” иргэний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөж, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт хангагдахгүй нөхцөл үүссэн байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт хуулийн үйлчлэх хүрээг “Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар тусгайлан зохицуулаагүй төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж тодорхойлжээ.

Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэг “Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна”, энэ зүйлийн 84.2 дэх хэсэг “Ажлын өдрийн үргэлжлэл найман цагаас илүүгүй байна”, энэ зүйлийн 84.4 дэх хэсэг “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” гэж, түүнчлэн ШШГТ хуулийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт “Хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жижүүрийн үүргийг 4 ээлжээр гүйцэтгэнэ” гэж заасан эрх зүйн зохицуулалтууд хэрэгжихгүй байгаа төдийгүй илүү цаг, амралтын болон баяр ёслолын өдрүүдээр ажиллуулсан нөхцөлд амраахгүй эсхүл илүү цагаар ажилласан олговрыг олгодоггүй байна.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтаар “цэргийн алба хаагчийг хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад хэм хэмжээнд зааснаас илүү цагаар ажиллуулах”, 8.2.2 дахь заалтад “захирагч, даргын шийдвэрээр цэргийн алба хаагчийн амралтын цагийг цэргийн дүрэмд заасны дагуу хязгаарлах” гэж цэргийн албаны онцлогоор цэргийн алба хаагчийн эрхийг хязгаарлах эрх зүйн зохицуулалтыг тусгасан нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажил, амралтын цаг, олговор олгох эрхийн хамгаалалтыг зөрчих үндэслэл болохгүй.

Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.2 дахь хэсэг “Нэг ээлжийн ердийн ажлын цагийн үргэлжлэл найман цагаас илүүгүй байна.”, энэ зүйлийн 87.3 дахь хэсэгт “Ажил олгогч ажилтантай тохиролцсоны дагуу хуульд өөрөөр заагаагүй бол ээлжийн ажлын цагийн үргэлжлэлийг дөрвөөс илүүгүй цагаар уртасган зохион байгуулж болно. Энэ тохиолдолд ажилтан долоо хоногт 40 цагаас илүү ажилласан бол түүнд илүү ажилласан цагийн хөлсийг энэ хуулийн 109.1-д заасны дагуу нэмж олгоно.” гэж тус тус зааснаар цэргийн алба хаагчийг 24 цагаар ажиллуулахыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хориглосон зохицуулалтууд хэрэгжээгүй байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 2.3-т заасан хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд хоорондоо зөрчилдвөл ажилтанд илүү таатай нөхцөлийг олгосон зохицуулалтыг хэрэглэнэ.” гэснийг дурдах нь зүйтэй.

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлд заасан “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах ...”, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... цалин хөлс авах, амрах...” иргэний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөж Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжилт хангалтгүй байна.

Тохиолдол

... Олон жил удирдах ажил хийж байгаа... Хорих ангид ямарваа нэгэн асуудал болоход цагдаа, ШШГЕГ-ын хяналт шалгалтын баг, прокурор, Хүний эрхийн Үндэсний комисс гээд албан тушаалтнууд хяналт шалгалт явуулж эцэст удирдах албан тушаалтан, албан хаагч буруудаад өнгөрдөг.асуудлын тогтолцооны шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлүүд хэвээрээ л байдаг ... алба хаагчид болон хорих ангиас олон асуудлыг шийдвэрлүүлэхээр санал, хүсэлт гаргадаг ч эцсийн дүндээ шийдвэрлэвэл зохих албан тушаалтандаа хүрдэг эсэхийг мэддэггүй....шийдвэрлэдэггүйИймд ЭШЭК-ын нэмэлт протокол, Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд зааснаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүнд туслах нэгжийг байгуулан ажиллуулах болсон нь бидний санал, хүсэлт зохих албан тушаалтандаа хүрэх боломжтой боллоо гэж дүгнэж байна.

(Хорих ангийн удирдах албан тушаалтантай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Урьд эрх чөлөө хязгаарлагдаж байсан иргэн Г.З-тай хорих ангид эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдөх явдлын шалтгаан нөхцөл, тэдгээр нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх мэдээллийг авч, мөн иргэн Ц.Г-ын гаргасан хүсэлтийн дагуу хууль бусаар цагдан хоригдсон, ял эдэлсэн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах болон түүний хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, хангах талаар зөвлөгөө өгсөн байна.

ШШГЕГ-ын Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангид хоригдож буй иргэн О.М, Ц.Х, н.М, Ц.Х нарын 7 иргэнтэй тэдгээрийн хүсэлтээр уулзаж эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар ярилцаж, санал хүсэлтийг сонсож хорих ангийн удирдлагад уламжлан шийдвэрлүүлэв.

3.1.1. ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал

1. Хорих ангиуд өөрийн онцлогт тохируулан зохих тэмдэглэгээг хийж, тухайн аюулгүйн тойрогт цагийн хуваарьт үйл ажиллагаа нэрийдлээр “хоригдлуудыг удаан хугацааны турш нэг газар суулган, шингэн зүйл уух, бие засах, биеийн чилээ гаргах хөдөлгөөн үйлдэх боломжгүйгээр хязгаарлаж байна” гэсэн нь хүний хөдөлгөөнийг удаан хугацаагаар хязгаарлаж байгаа хүнлэг бус харьцааны хэлбэр гэж дүгнэлээ.

ХЗДХ-ийн сайд, УЕП-ын 2017 оны А/192, А/81 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлын тойрог тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Хорих байгууллага нь аюулгүйн тойргийн хэмжээ мөрдөгдөх боломжгүй газарт хорих байрны зохион байгуулалт, онцлогт тохируулан хана, шалны хэсэгт хоригдогчийн хөдөлгөөнийг хориглосон, тэмдэглэгээг хийнэ”, энэ зүйлийн 3.3 дахь хэсэгт “Хорих өрөөний дотор болон гадна талд хаалганаас 1 метрийн зайд үргэлжилсэн шугамаар хөдөлгөөн хязгаарласан шалны тэмдэглэгээг хийнэ”, энэ журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хоригдогч аюулгүйн тойрогт зөвшөөрөлгүй нэвтэрсэн, хөдөлгөөнийг хориглосон тэмдэглэгээг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулна” гэж тус тус заасан.

ШШГТ хуулийн 211 дүгээр зүйлийн хоригдлын үүргийн энэ зүйлийн 211.1 дэх хэсэгт “хорих ангид мөрдөх хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий албан тушаалтнаас баталсан дүрэм, журам, хорих байгууллага, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг заавал биелүүлэх”, энэ зүйлийн 211.2 дахь хэсэгт “хорих байгууллагаас тогтоосон цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдөх” гэж заасан байна.

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг³⁶ Монгол Улсад хийсэн айлчлалын хүрээнд хийсэн хяналт шинжилгээний урьдчилсан дүгнэлтэд “... Түүгээр ч барахгүй хоригдлууд маш хатуу дэглэмд захирагддаг ба зарим шаардлагыг нь доромжлол, хүнлэг бус хандлага гэж ойлгож байна. ... Хоригдлуудад энэхүү улаан шугам дээр гишгэхийг хориглодог Хоригдлуудад улаан шугамыг давж гарахыг хориглодог практикийг нэн даруй халах ёстой...” гэж дурдсан.

2. ШШГ байгууллагын цагдан хорих болон хорих ангид сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэний анхан шатны мэдээллийг цуглуулан сэтгэл зүйн байдлыг оношлон тодорхойлох, дарамт, стрессээс гарахад нөлөөлөх, нөхөн сэргээх, тусламж үзүүлэх дохионы хэлний хэлмэрчийн мэдлэгтэй алба хаагчтай байх шаардлагатай. Тухайлбал, цагдан хоригдож буй сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэн н.М-тэй алба хаагч харилцан ойлголцоогүй гэх хүний эрхийн зөрчлийн тухай гомдол ХЭҮК-т шалгагджээ.

³⁶ Монгол Улсын Засгийн газрын урилгаар НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн 2022 оны 10 дугаар сарын 3-14-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн.

Мөн хяналт шинжилгээний хүрээнд асуумжид хамрагдсан алба хаагчдын 25.6% нь “монгол хэл, бичиг мэддэггүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудад хорих байрны дотоод журам, цагийн хуваарь, сахилгын шийтгэл ногдуулах журам, эрх үүргийг тайлбарлахад бэрхшээл тулгардаг” гэж хариулжээ.

3. НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй”, Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “халдашгүй, ... байх эрхтэй. ... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй...” гэж тунхагласан.

Түүнчлэн ШШГТ хуулийн 273 дугаар зүйлд алба хаагчийг энэ зүйлийн 273.2.1 дэх заалт “хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах”, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд алба хаагчийг энэ зүйлийн 10.3.5 дахь заалт “хоригдсон этгээдтэй хүнлэг бус харьцах”-ыг тус тус хориглосон.

Гэвч Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн дэд дарга асан хурандаа Э.Б нь 2022 оны 3 дугаар сард хоригдогч М.М-ыг биед халдсан үйлдлийг Нийслэлийн Прокурорын газраас 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хяналт, шалгалтаар тогтоон эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан төдийгүй, мөн тус онд Өмнөговь аймгийн ШШГГ-ын ахлах шийдвэр гүйцэтгэгч Д.Ж нь иргэн Д.О-г хэл амаар доромжилж, зодсон гэх гэмт хэргийн шинжтэй гомдол нь Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасагт ЭХХШТ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалгагджээ.

4. ХЗДХ-ийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны А-240/А-369 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын 5.1 дүгээр зүйлд “Хамгаалалтын нэг ээлжид 3-аас доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулна” гэсэн заалтыг зөрчин нэг алба хаагчаар хамгаалалтын үүрэг гүйцэтгүүлж байсныг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжид тусгасан.

Гэвч хяналт шинжилгээ хийгдэж зөвлөмж өгөгдсөний дараа буюу СЭМҮТ-ийн ШСЭСК-т 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр албадан эмчлүүлэгч Ө.Х нь усанд орох өрөөний дулааны шугамаас боомилсон байдалтай нас барсан харамсалтай тохиолдлыг дээрх журмын хэрэгжилтийг хангаагүйгээс амиа хорлох үйлдлийг таслан зогсоох боломж хязгаарлагдсан гэж дүгнэх үндэслэлтэй байна.

5. НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн хяналт шинжилгээний урьдчилсан дүгнэлтэд “... бүх хорих ангиуд ялтнуудад 7 хоногт нэг л удаа махтай хоол өгдөг, бусад өдрүүдэд малын гэдэс, цувдайтай хоол өгдөг... хоолны тэжээллэг чанар муу байгаад Ажлын хэсэг санаа зовниж байна. Ажлын хэсэг ЗГ-аас асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэж, ялангуяа Хоригдолтой харьцах Нельсон Манделагийн дүрмийн 22 дугаар заалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг уриалж байна....” гэж дурджээ.

Хяналт шинжилгээ хийх явцад асуумжид хоригдсон хүн хоолны тэжээллэг чанар, хүртээмж муу байгаа талаар байнга дурдагдаж байгаагийн зэрэгцээ “... ХЭҮК-ын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллах үеэр л ...махтай хоол бидэнд өгч байна. ... ” гэж ярьсныг анхаарах шаардлагатай.

6. Цагдан хорих анги, хорих ангиудад хоригдож буй хүмүүсийн наад захын хэрэгцээ шаардлагыг хангахаар худалдаалагдаж буй зөвшөөрөгдсөн бараа, бүтээгдэхүүний үнэ харилцан адилгүй, хадгалах хугацаа ихэнхдээ дууссан байдаг бөгөөд ялангуяа

эмэгтэйчүүдийн хэрэгцээт бүтээгдэхүүний хангалт, сонголт, чанар муу байдгаас үүдэлтэй эрүүл мэндэд сөрөг үр дагавар гардаг талаар асуумжид дурдагдсан.

7. ШШГЕГ болон харьяа анги, нэгжийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрт эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг алба хаагч, хоригдсон хүнд тайлбарлан таниулах, ЭШУС агуулга бүхий арга хэмжээ, үйл ажиллагаа тусгагдаагүй.

3.1.2. Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангид хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал

Асуумжид оролцсон 352 цагдан хоригдож буй хүн холбогдох хуульд заасан эрхийн хэрэгжилтийг доорх байдлаар дүгнэснийг үйл ажиллагаандаа анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Асуумжид оролцсон нийт хоригдогчдын 18,3% нь “эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт үзүүлэх, эмчлүүлэх эрх огт хэрэгждэггүй” гэж, ганцаарчилсан ярилцлагад оролцсон хоригдогчид өвдөлт намдаах зэрэг наад захын эмийн хангалт муу байдаг талаар дурдсан.

Тус хорих ангийн удирдлага, эмнэлгийн эмч нар тус албанд ажиллах хүний нөөц дутмаг байгаа нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэхэд бэрхшээл дагуулж буй төдийгүй хоригдогчийн зүгээс байнга эмнэлэгт үзүүлэх санал хүсэлт гаргах, эмчийн зөвшөөрөлгүй эм хэрэглэх хандлагатай байдаг талаар дурдсан.

2. Асуумжид оролцсон нийт хоригдогчдын 27,7% нь “цагдан хорих ангийн дотоод журамд заасны дагуу захидлаар харилцах, бичгийн хэрэгсэл ашиглах эрх огт хэрэгждэггүй”, 23,7% нь “өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах баримт бичиг, бичлэгийг биедээ хадгалах эрх огт хэрэгждэггүй”, 15,1% нь “шаардлагатай илчлэг бүхий хоол, унтах байр, дэвсгэр, хучлагаар хангагдах эрх огт хэрэгждэггүй”, 12% нь “цагдан хорих ангийн дарга болон цагдан хорих ангийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтантай хорих ангид ажиллах үеэр нь хувиараа уулзах эрх огт хэрэгждэггүй”, 9,1% нь “цагдан хорих ангийн дотоод журмыг тайлбарлан өгч, эдлэх эрх, хүлээх үүрэгтэй холбогдуулан байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрх огт хэрэгждэггүй” гэж тус тус хариулсныг үйл ажиллагаандаа анхаарч дахин судлах шаардлагатай байна.

3. Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангийн алба хаагч нь дохионы хэлний мэдлэггүйгээс цагдан хоригдож буй сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэний анхан шатны мэдээллийг цуглуулан сэтгэл зүйн байдлыг оношлон тодорхойлох, дарамт, стрессээс гарахад нөлөөлөх, нөхөн сэргээх, тусламж үзүүлэх замаар сэтгэл зүйг тогтворжуулах орчин бүрдүүлээгүй байна.

4. НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй”, Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “халдашгүй, ... байх эрхтэй. ... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй...” гэж тунхагласан.

Түүнчлэн ШШГТ хуулийн 273 дугаар зүйлд алба хаагчийг энэ зүйлийн 273.2.1 дэх заалт “хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах”, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд алба хаагчийг энэ зүйлийн 10.3.5 дахь заалт “хоригдсон этгээдтэй хүнлэг бус харьцах”-ыг тус тус хориглосон.

Гэвч Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн дэд дарга асан хурандаа Э.Б нь 2022 оны 3 дугаар сард хоригдогч М.М-ыг биед халдсан үйлдлийг Нийслэлийн Прокурорын газраас 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хяналт, шалгалтаар тогтоогдож, Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газарт хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, мөрдөн шалгагдсан ч гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

5. Мөн хуулиар олгогдсон эргэлт авах эрхийг ажлын бус өдрүүдэд тааруулан зохион байгуулах, цагдан хорих ангийн дэлгүүрт худалдаалагдаж буй бараа, бүтээгдэхүүний хадгалах хугацаа ихэнхдээ дууссан байдаг бөгөөд ялангуяа эмэгтэйчүүдийн арьс арчилгааны бүтээгдэхүүний хангалт, сонголт, чанар муу байдгаас үүдэлтэй сөрөг үр дагавар гардаг талаар ярьж байв.

6. Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид хоригдож буй хүмүүстэй ганцаарчлан уулзаж ярилцахад хоригдогчдын олонх нь "... алба хаагчид хэл амаар доромжлон ялгаварлан харьцдаг, тухайлбал огт хулгай хийж үзээгүй хүнийг үргэлж хулгайчаа гэж дууддаг... харилцааны соёлгүй" гэж, хоригдож буй бэлгийн болон хүйсийн цөөнх 2 хоригдогчтой уулзаж ярилцахад "... хамт хоригдогчдын зүгээс заналхийлдэг, алба хаагчид бидний талаар ямар ч мэдлэг, ойлголт байхгүй бөгөөд үргэлж загнаж, зандарч харьцдаг, эмэгтэй алба хаагчид нь "нөгөөх чинь" гэж хоорондоо ярилцдаг, ер нь "нөгөөдөх" гэдэг нэртэй болсон" талаар дурджээ.

3.1.3. ШШГЕГ-ын харьяа Баривчлах байранд хийгдсэн хяналт шинжилгээ

1. Баривчлах шийтгэл эдэлж буй 172 хүнээс ШШГТ хуульд заасан эрхийн хэрэгжилтийг доорх байдлаар дүгнэснийг үйл ажиллагаандаа анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Асуулт 1. "Баривчлах шийтгэл эдлэх нөхцөл, журам, эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах эрх огт хэрэгждэггүй" 20.6 %,
- Асуулт 2. "Баривчлах байрны захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрх огт хэрэгждэггүй" 36.4 %,
- Асуулт 3. "Өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрх огт хэрэгждэггүй" 50.7%,
- Асуулт 4. "Эмнэлгийн тусламж авах эрх огт хэрэгждэггүй" 25.5 %,
- Асуулт 5. "Баривчлах байрны алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах эрх огт хэрэгждэггүй" 27.9 %,
- Асуулт 6. "Хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах эрх огт хэрэгждэггүй" 25.1 %,
- Асуулт 7. "Өөрөө зөвшөөрсөн эсэхээс үл хамааран эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй аливаа туршилтаас ангид байх эрх огт хэрэгждэггүй" 17.4 %,
- Асуулт 8. "Холбогдох журмын дагуу зөвшөөрөгдсөн тоо, хэмжээний хоол, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн болон нэн тэргүүний бусад зүйл худалдан авах эрх огт хэрэгждэггүй" гэж 32.1 %,
- Асуулт 9. Шашны зан үйл үйлдэх эрх огт хэрэгждэггүй гэж 57.8 %,
- Асуулт10. "Хуваарилагдан очсон баривчлах байрны байршил, холбоо барих мэдээллийн талаар гэр бүлийн гишүүнд мэдэгдэх эрх огт хэрэгждэггүй" гэж 25 %

Асуулт 11. “7 хоногт нэг удаа 1 цаг хүртэл хугацаагаар бусадтай уулзалт хийх, нэг удаа илгээмж авах, нэг удаа захидал илгээх эрхээ эдэлж чаддаггүй ” гэж



38,3 %.

1. ШШГТ хуулийн 146 дугаар зүйлийн 146.4 дэх хэсэгт “Баривчлагдсан этгээд өдөрт 1 цагаас доошгүй хугацаагаар гадаалах, биеийн тамирын дасгал хийх болон 7 хоногт нэг удаа 5 минутаас ихгүй хугацаагаар утсаар ярьж болно”, ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Баривчлах байрны дотоод журам”-ын 7.9.2-д “хэт халуун, хүйтэн зэрэг цаг агаарын хүндрэлтэй үед гадаалуулах эсэхийг төв /байр/-ийн дарга шийдвэрлэнэ” гэж тус тус заасан.

Гэвч баривчлагдсан хүнээс “өдөрт 1 цагаас доошгүй хугацаагаар гадаалах, биеийн тамирын дасгал хийх, 7 хоногт нэг удаа 5 минутаас ихгүй хугацаагаар утсаар ярих эрхээ эдэлж чадаж байгаа эсэх” гэсэн асуумжид 89 буюу 60.1% нь “үгүй” гэж хариулсан нь баривчлагдсан хүний хуулиар олгогдсон эрх зөрчигдөж байна гэж үзэх үндэслэлтэй байв.

2. Мөн Баривчлах байрны алба хаагч “Тантай зүй бусаар харьцаж байсан уу?” гэсэн асуултад 46.5% нь тийм гэж, улмаар алба хаагчийн нэр зааж, түүний хууль бус үйлдлийг байнгын давтагдах шинжтэй байдаг гэж, “Баривчлах байранд хүнлэг бус хэрцгий хандах, ялгаварлан гадуурхалтад өртөж байна уу?” гэсэн асуултад 20.7% нь тийм, “Баривчлах байранд бусад хүний зүгээс хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалт байдаг эсэх?” гэсэн асуултад 8.8% нь тийм гэж тус тус хариулсан нь баривчлах байрны алба хаагчдаас баривчлагдсан хүний эрхийг зөрчиж байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон.

3. Баривчлагдсан хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийхэд баривчлах байрны бие засах газар нь маш бохир, тохьгүй, эрэгтэй хүний шээлтүүр (писсуар) байхгүй, яр шарх, хатги, бөөс, архинд донтсон хүмүүсийг тусад нь байрлуулдаггүй, бусад хүмүүстэй хамт нэг өрөөнд байрлуулж байна, хоолны амт чанар муу, бүрэн буцлаагүй, болоогүй хоол унд өгснөөс хүмүүс их гүйлгэдэг, бүхэл мөнгөний хариулт өгдөггүй, олон хоносон мантуун бууз, 1 кг хүрэхгүй боорцгийг өндөр үнэтэй зардаг, эмчид үзүүлэхэд энэ бол эмнэлэг биш гээд эм тариа өгдөггүй, эмнэлгийн тусламж үзүүлдэггүй талаар олонтоо дурдагдсан.

4. Баривчлах байрны 3 дугаар давхарт 100 гаруй эрэгтэй баривчлагдсан хүнд нэг эмэгтэй алба хаагч хяналт тавьж ажиллаж байсан бөгөөд алба хаагчтай ярилцахад “... энэхүү давхарт ганц эмэгтэй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэж хонох хэцүү байдаг. Удирдлагуудад хэлэхээр дээшээ уламжилна гээд огт шийдэгддэггүй. Ядаж ахиад нэг эрэгтэй хамгаалалтын алба хаагчтай хамт гарвал ажлын ачаалал багасна...” гэж хариулсан.

5. Баривчлах байранд эргэлт, уулзалтаар ирсэн иргэдтэй уулзахад гадаа удаан хугацаагаар хүлээдэг, харин алба хаагчид шалган нэвтрүүлэх байргүй, уулзалтын өрөөний хүртээмжээс шалтгаалан уг байранд нэвтрүүлэх боломжгүй байдаг талаар тус тус дурдсан.

6. Алба хаагчдаас “Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг зөрчсөн талаар баривчлагдсан хүнээс санал, гомдол гарч байсан уу?” гэсэн асуумжид “тийм” гэж хариулан, улмаар энэ талаар тайлбар мэдээлэл өгөхгүй байх, нуун дарагдуулахыг удирдлагаас даалгаж байсан талаар дурдагдсан.

7. НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд “...Эцэст нь дурдахад баривчлагдсан этгээд эдгээр баривчлах байранд саатуулагдах хугацаандаа өдрийн 3800 төгрөгийн төлбөр төлөх үүрэг хүлээж байна. Зарим баривчлагдсан этгээд баривчлах байранд засвар үйлчилгээний ажил хийгээд, ажил хийсэн хугацаандаа баривчлах байрны төлбөрөөс чөлөөлөгдөж байна.

Ажлын хэсэг нь хүний эрх чөлөөг хасах нь хамгийн эцсийн шатанд авах арга хэмжээ байх ёстой гэдгийг сануулаад, Зөрчлийн хуулийн дагуу шийтгэл оногдуулж буй үйлдлүүдийн цар хүрээний хувьд санаа зовниж буйгаа илэрхийлж байна. Пактын 9 дүгээр зүйлд заасны дагуу хүний эрх чөлөөг хангах үүднээс баривчлах шийтгэл оногдуулж буй үйлдлүүдийн цар хүрээг Засгийн газар дахин нэг нягталж үзэх нь зүйтэй. Мөн баривчлагдсан этгээд нь баривчлах байранд саатуулагдсанахаа төлөө ямар нэгэн төлбөр төлөх үүрэг хүлээхгүй байх нь зүйтэй. Эцэст нь дурдахад хэдий саатуулах хугацаа нь богино байсан ч хүнийг дур мэдэн саатуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд хэрэгжих ёстойг сануулж, зайлшгүй хийгдэх процессын баталгааг, ялангуяа хууль зүйн туслалцаа авах эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг зөвлөж байна.” гэжээ.

3.1.4. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмж

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний ШШГЕГ-ын даргад 11 заалт бүхий, ШШГЕГ-ын Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн даргад 11 заалт бүхий, ШШГЕГ-ын Баривчлах байрны даргад 11 заалт бүхий Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 35.3 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор бичгээр хариуг ирүүлэх Зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийн дагуу ШШГЕГ-ын даргаас 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/226 дугаартай албан бичгээр, ШШГЕГ-ын Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн даргаас 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/225 дугаартай албан бичгээр, ШШГЕГ-ын Баривчлах байрны даргаас 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/33 дугаартай албан бичгээр Зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж байгаа ажлын талаарх танилцуулгыг тус тус ирүүлсэн байна.

3.2. Цагдаагийн байгууллагад хийгдсэн хяналт шинжилгээ

ЭШУС хэлтэс нь тайлангийн хугацаанд Нийслэлийн цагдаагийн газрын харьяа Эрүүлжүүлэх, саатуулах төв, Говь-Сүмбэр, Өмнөговь, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Архангай, Завхан аймаг болон Тосонцэнгэл сумын сум дундах цагдаагийн хэлтэс зэрэг нийт 17 байршилд хяналт шинжилгээ хийлээ.

Түүнчлэн 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхэлсэн иргэдийн жагсаал, цуглааны үеэр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн ЦЕГ-ын дэд даргатай уулзаж³⁷, хүний үндсэн эрх, эрх чөлөөнд нэн хүндэтгэлтэй хандаж, хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах, эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хандахгүй байхад анхаарч ажиллахыг уриалав³⁸.

Мөн жагсаал, цуглаан цаашид олон хоног үргэлжилбэл алба хаагчдын үүрэг гүйцэтгэх ээлжийг оновчтой зохион байгуулж, ялангуяа цагдаагийн алба хаагчдын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл, бололцоог хангахад анхаарч, цаг агаарын болон бусад нөхцөл байдалтай уялдуулж, дулаан хувцас, бусад шаардлагатай зүйлээр даруй хангах, ажил, амралтын цагийг зөв зохицуулж, алба хаагчдынхаа эрх ашгийг хамгаалж ажиллахыг зөвлөснөөс гадна жагсагч н.Б-ын жагсаал цуглааны үед хүний эрх хангагдахгүй байгаа талаар санал гомдлыг биечлэн хүлээн авч, зохих шатны байгууллагад уламжлав.

3.2.1 Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх, түр саатуулах байрны өнөөгийн нөхцөл байдал

ЦЕГ-ын харьяа Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын Эрүүлжүүлэх саатуулах төв, байрны үйл ажиллагааг дараах эрх зүйн актуудаар зохицуулж согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллагын хяналтад авч, албадан эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлэн ажилладаг байна.³⁹ Үүнд:

- “Цагдаагийн албаны тухай хууль”,
- “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль”,
- Хууль зүйн, дотоод хэргийн сайдын 2020 оны А/192 дугаар тушаалаар баталсан “Саатуулах байрны дэглэм, журам”,
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код-622, 629 “Албадан эрүүлжүүлэх журам”,
- Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2022 оны А/81 А/232 дүгээр тушаалаар батлагдсан “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх журам”

³⁷ ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн ЦЕГ-ын дэд дарга П.Оростогоотой жагсаал, цуглааны үеэр иргэд, алба хаагчдын эрхийг хангаж ажиллах талаар уулзаж, зөвлөлдлөө - ХЭҮК (nhrcm.gov.mn)

³⁸<https://www.facebook.com/nhrcm/>

³⁹ Цагдаагийн Ерөнхий газрын харьяа Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтэст ирүүлсэн мэдээллээс

Улсын хэмжээнд 1964-
2017 оны хооронд
ашиглалтад орсон

НИЙТ
37



НИЙСЛЭЛ
9

АЙМАГ
21

СУМДАД
7



Газар,
хэлтсийн
байранд 18



Хонгилд буюу
подвальд 10



Тусдаа
байртай 19


Улсын хэмжээнд 1964-2017 онуудад ашиглалтад орсон цагдаагийн байгууллагад 37 байр байгаагаас цагдаагийн газар газар, хэлтсийн байранд 18, хонгилд 10, тусдаа байртай 19 байна.

Нийслэлд 9, аймагт 21, сумдад 7 эрүүлжүүлэх саатуулах байр үйл ажиллагаа явуулж байна.⁴⁰

Сүүлийн 4 жилийн байдлаар
239.293 хүн эрүүлжүүлэгдсэн



2020 онд	17216 нэгж	↓	- 15.4 %
2021 онд	23384 нэгж	↓	- 24.3 %
2022 онд	6600 нэгж	↓	- 9.3 %
2023 оны 2 сард	5030 нэгж	↓	- 38.3 %



Сүүлийн 4 жилийн байдлаар 239293 хүн эрүүлжүүлэгдсэн байна, Тухайлбал, 2022 оны байдлаар 58,400 хүнийг эрүүлжүүлэх, саатуулах 416 өрөөнд албадан саатуулж, эрүүлжүүлснээс 36 нь эмэгтэй, 20 нь насанд хүрээгүй иргэн байжээ.

Сүүлийн 4 жилийн байдлаар 10198 ухаангүй буюу согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүний тухай дуудлага мэдээллийг цагдаагийн байгууллага хүлээн авч түүнээс Яаралтай түргэн тусламжид 2986 дуудлага өгч 509 хүн эрчимт эмчилгээ, хагалгаанд оржээ.

Сүүлийн 4 жилд	Нийслэлд	Орон нутагт
Ухаангүй унасан	10198	5889
Уүнээс 103-т өгсөн	2986	2239
Уүнээс хагалгаа, эрчимт эмчилгээнд	509	291
		4309
		747
		218

⁴⁰ ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны мэдээллээс ...

Гэвч сүүлийн 4 жилийн хугацаанд 17 хүн Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Эрүүл



НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ,
ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ АЛБА

НАС БАРСАН ХҮН /4 жилийн байдлаар/


2020 он – 5 хүн

2021 он – 6 хүн

2022 он – 3 хүн

2023 оны эхний 2 сарын байдлаар 3 хүн нас барсан.

СҮҮЛИЙН 4 ЖИЛД
17 ХҮН НАС БАРСАН



мэндээ хамгаалуулах, эмнэлгийн төлбөргүй тусламж авах” эрхээ эдлэх боломж хязгаарлагдаж, эрүүлжүүлэх байранд нас баржээ.

Эдгээр тохиолдлуудад түргэн тусламж /103/-ийн эмч, нарийн мэргэжлийн эмчийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай гэмтэл биедээ авсан, хүнд болон халдварт өвчтэй, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж хордсон эсэхийг тогтоохгүйгээр эрүүлжүүлэх байранд хүргэгдсэн байна.

Мөн зарим тохиолдолд түргэн тусламжийн эмч хугацаа

алдаж ирснээс тухайн дуудлага мэдээллийн шийдвэрлэлт удааширдаг, цагдаагийн алба хаагчид дараагийн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага мэдээлэлд хугацаа алдаж очих, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учрах эрсдэл үүсдэг байна.

Түүнчлэн хордлого тайлах эмчилгээг төлбөртэй хийдэг учир согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, хордлогод орсон тэнэмэл болон төлбөрийн чадваргүй, бичиг баримтгүй, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийг дүүргийн нэгдсэн эмнэлэгт хүргэж хүлээлгэн өгөхөд хүлээн авахаас татгалздаг, ар гэр, асран хамгаалагчдыг нь ирүүлэхийг шаарддаг учраас Нийслэлийн Түргэн тусламж /103/-ийн эмч нар эдгээр иргэдийг авч явахаас зайлсхийдэг гэсэн дүгнэлтийг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны мэдээлэлд дурджээ.

Мөн цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх саатуулах байранд тулгарч буй дараах хүндрэл бэрхшээлийг дурдсан байна. Үүнд:

- Зарим эрүүлжүүлэх саатуулах байр стандарт шаардлага хангадаггүйгээс ХЭҮК болон прокурорын байгууллагаас байнга шаардлага зөвлөмж авдаг тул стандартын шаардлага хангасан байртай болох, байрны нөхцөл байдлыг сайжруулах;
- Үйлчлэгчийн орон тоо байхгүй, цэвэрлэгээ үйлчилгээ туйлын хангалтгүй тул үйлчлэгчийн орон тоог батлуулах;
- стандарт, шаардлагад нийцсэн эм тариа худалдан авах төсөв мөнгө дутагдалтай
- алба хаагч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх;
- зарим байранд камерын хяналтын системийг сайжруулах, агааржуулалтын систем тавих, халаалтын системийг сайжруулах;
- эмчийн батлагдсан орон тооны дагуу хүний нөөцийг хангах.

3.2.2 Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд "...Цагдаа нар анхнаасаа иргэдийг цагдаагийн хэлтэс рүү гэрчээр дуудах нь


хэвийн үзэгдэл бөгөөд дуудагдсан хүмүүс үнэн хэрэгтээ чөлөөтэй явах эрхгүй байдаг тухай Ажлын хэсэг олон хүнээс сонссон.

Ийм нөхцөлд цагдаагийн хэлтэст бүтэн өдрийг өнгөрөөж байсан боловч энэ хугацааг зөвшөөрөгдсөн 6 цаг болон 48 цагт албан ёсоор тооцон оруулдаггүй гэж тэд мэдээлж байв. Цагдаагийн газарт тухайн хүнээс мэдүүлэг авах үед тавьж буй асуултуудаас нь түүнийг сэжигтнээр тооцож байгаа нь тодорхой болдог ч, хүмүүсийг ээрчээр мэдүүлэг өгнө үү хэмээн дууддаг байна.

Үүнээс болж сэжигтэн нь өмгөөлөгчтэй зөвлөлдөх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх зэрэг чухал хамгаалалтаа ашиглаж чадахгүй байж болзошгүй юм.

Цаашилбал, тухайн хүн цагдаагийн хэлтэст зөвшөөрөгдсөн 6 цагийн турш албан ёсоор хоригдсон бол тухайн 6 цаг нь 48 цагийн хугацаанд тооцогддоггүй. Бодит байдал дээр дийлэнх тохиолдолд цагдаагийн албадан саатуулах хугацаа нь зөвшөөрөгдсөн дээд хэмжээ буюу 48 цагаас илт давж байсныг Ажлын хэсэг онцлон тэмдэглэж байна.” гэжээ.

Мөрдөгч, прокурор, бусад хүний зүгээс танд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, ялгаварлан гадуурхах үйлдэл гаргасан уу?



ШШГЕГ-ын харьяа хорих 461 дүгээр хаалттай ангид явуулсан хяналт шинжилгээний үеэр эрх чөлөөгөө хязгаарлуулсан 331 хүнээс мөрдөгч, прокурор, бусад хүний зүгээс эрүү шүүлт, зүй бус харьцаа гаргасан эсэх асуумж авахад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, ялгаварлан гадуурхах үйлдэлд өртсөн гэж 33% нь буюу 108 хүн, үгүй гэж 65% хариулсан бол 6 хүн хариулаагүй байна.

Түүнчлэн Ахмад настны үндэсний төвд үйлчлүүлэгч Я.С нь 2022 оны 07 дугаар сарын 23-ны өдөр бусадтай маргалдаж гэмтсэн гэсэн агуулга бүхий гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллээр цагдаагийн алба хаагч ирсэн байна.

Гэвч хяналт шинжилгээгээр прокурор, цагдаагийн байгууллагын албан бичигт дурдсанаар энэхүү гэмт хэргийн тухай гомдол бүртгэгдэж, шалгагдаагүйгээс Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д заасан “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” үндсэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн байна.

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд “... Мөн түүнчлэн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байхгүйн улмаас зөрчлийн хэрэгт холбогдогч нь эрүүгийн шүүхээр хэргээ шийдвэрлүүлж байна.

Практикт эрүүгийн шүүх нь эрүүгийн хэргийг түрүүнд нь шийдвэрлэж байгаа учраас зөрчилд холбогдогч нь шүүх хурал болох хүртэл дунджаар 4 цаг орчим хүлээх шаардлагатай болж байна. Хүмүүсийг өглөө шүүх хуралдаантай гэж дуудчихаад, хүлээх суух газар ч гаргаж өгөхгүйгээр үдээс хойш хүртэл шүүх хуралдаан нь болохгүй хүлээлгэх нь бараг хэвийн үзэгдэл болсон байна. Гэтэл зөрчлийн хэрэг шийдвэрлэх шүүх хуралдаан нь маш богино буюу 15-20 минутын хугацаанд л үргэлжилдэг. Холбогдогч хууль зүйн туслалцаа авах эрхтэй хэдий ч энэ нь үнэ төлбөргүй биш учраас шүүх хуралдаанд ихэвчлэн хууль зүйн туслалцаа авалгүйгээр оролцож байна.

Анхан шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор тухайн шийдвэрт гомдол гаргах боломжтой боловч баривчлах хугацаа нь богино бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу баривчлах шийтгэл оногдуулмагц баривчлагдсан этгээдийг шууд баривчлах байранд аваачиж байгаа учраас шүүхийн шийдвэрт гомдол гаргах тохиолдол практикт ховор байна.” гэжээ.

3.2.3 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмж

Хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/01 тоот албан бичгээр Төв аймаг дахь Цагдаагийн газрын даргад хүргүүлсэн.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 08/01 дугаартай Зөвлөмжийг ЦЕГ-ын даргад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хамгаалах, хангах, ялангуяа улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 13.9 /Хууль бусаар баривчлах/, 14.1 /Ялгаварлан гадуурхах/, 21.12 /Эрүү шүүлт тулгах/ гэмт хэргүүдэд цагдаагийн алба хаагч холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2023 онд цагдаагийн байгууллагын хэмжээнд төлөвлөн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах талаар хүргүүлсэн байна.

3.3. Ахмад настны Үндэсний төв

3.3.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төвүүд

Монгол Улсад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг 8, зардлыг хэсэгчлэн санхүүжүүлдэг хувийн хэвшлийн 2, шашны байгууллагын санхүүжилттэй 2, нийт 12 асрамжийн төв үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээрээс Төв аймгийн Батсүмбэр суман дахь Ахмад настны үндэсний төв, Увс, Дорнод, Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа асрамжийн төвүүд улсын төсвөөс санхүүждэг бол Баянхонгор, Баян-өлгий, Ховд, Хөвсгөл аймгийн ХХҮГ-ын харьяа асрамжийн төвүүд нь орон нутгийн төсвөөс санхүүждэг.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо, Баянцагааны 6-10 тоот хаягт байршилтай “Батгэрэлт-Ирээдүй” ТББ-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн төв, мөн Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороо, Хөтөл 1-5 тоот хаягт байршилтай “Ачлалт хүүхдүүд” хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн төв, Хан-Уул дүүргийн 6 дугаар хороо, Ноосны үйлдвэрийн 31-84, Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо, Бэлхийн 33-2-32, 33 тоот хаягт байрладаг “МС Тереза эх” ахмад настны асрамжийн төвүүд нь шашны байгууллагаас тус тус санхүүждэг.

Улсын хэмжээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад 2021 оны 12 дугаар сарын байдлаар нийт 386 хүн үйлчлүүлж, энэ салбарт 250 гаруй ажилтан ажиллаж байна.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгчдийн хоол хүнс, хувцас, зөөлөн эдлэл, ариун цэврийн хэрэгсэл, асрамжийн газарт зайлшгүй байх эм, тарианы жагсаалт, зардлын норм, нормативыг хэрэглээний үнийн индекстэй уялдуулан 42 хувиар нэмэгдүүлж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалаар шинэчлэн баталж 2022 оноос эхлэн дагаж мөрдөж байна.

Мөн УИХ-аас 2017 онд шинэчлэн баталсан Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д “Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай ахмад настны асрамжийн газрыг төрөөс бодлогоор дэмжиж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх ба санхүүжүүлэх журмыг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасны дагуу Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/03/03 дугаар хамтарсан тушаалаар батлан уг тушаалын хүрээнд одоо үйл ажиллагаа явуулж байгаа хувийн асрамжийн газруудад үйлчлүүлж буй иргэдийн зардлын нормативын дагуу хэсэгчилсэн санхүүжилт олгож байна.

3.3.2. Ахмад настны Үндэсний төвд хийгдсэн хяналт шинжилгээ

АНҮТ нь Нийгмийн халамжийн тухай хууль /цаашид НХТ хууль гэх/, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 дугаар тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”, Асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх, ажил, үйлчилгээ явуулах эрх олгох журам”, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын А/156 дугаар тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам” болон Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 5823:2016” стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

3.3.2.1. Төвийн үйл ажиллагааны онцлог:

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2022 оны 08 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд хяналт шинжилгээ явууллаа.

АНҮТ нь 1925 онд “Өнчин ядуусыг тэтгэх газар” нэртэйгээр анх байгуулагдсан улсын ууган асрамжийн төв бөгөөд 1925 оноос хойш 32 жилийн туршид Нийслэл хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаад 1957 онд Хэнтий аймгийн Цэнхэр мандал сум, 1967 онд Төв аймгийн Батсүмбэр суманд шилжин суурьшсан үеэс 2013 оныг хүртэл “Улсын асрамжийн газар” нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 55 дугаар тогтоолоор ХХҮЕГ-ын харьяа “Ахмад настны үндэсний төв” болгон улмаар 100 үйлчлүүлэгч нэмж авах хүчин чадалтай өргөтгөл болон 150 ортой амралт, нөхөн сэргээх сувиллын барилгыг шинээр ашиглалтад оруулснаар хоёр байранд 118 ажилтантайгаар нийт 157 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үзүүлж байна.

ХНХ-ын сайдын “Ахмад настны үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц, дүрмийг шинэчлэн батлах тухай” 2022 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн А/107 дугаар тушаалын дагуу тус байгууллагын Сувилахуйн төв нь 63 ажилтантайгаар ажиллах ёстой боловч 45 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Хүснэгт 1. АНҮТ-өөр үйлчлүүлэгчдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн төрөл

№	Үзүүлэлт	Тоо	%
Хүйс			
1	Эрэгтэй	96	61.1
2	Эмэгтэй	61	38.8

Тэтгэврийн насанд хүрсэн эсэх			
3	Тэтгэврийн насанд хүрсэн	125	79.6
4	Тэтгэврийн насанд хүрээгүй	27	17.1
Хөгжлийн бэрхшээлийн төрөл			
5	Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй /байнгын асаргаанд байдаг/	44	28
6	Сэтгэцийн хамааралт эмгэгтэй	138 /давхардсан тоогоор/	87.8
7	Хөдөлгөөний бэрхшээлтэй /тулгуур эрхтний/	77 /давхардсан тоогоор/	49
8	Харааны бэрхшээлтэй	12	7.6
9	Сонсголын бэрхшээлтэй	5	3.1
10	Хэл ярианы бэрхшээлтэй	22	14

Асуумж, ярилцлагын үр дүн: АНҮТ-өөр үйлчлүүлж буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс асуумж, ярилцлагад оролцох боломжтой гэж үзсэн 19 хүн, төвд ажилладаг 8 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Захиргаа, нийгмийн оролцооны алба, Дэмжих үйлчилгээ, хангамжийн алба, Сувилахуйн төвийн 25 ажилтан, албан хаагчаас тус тус асуумж авч, ярилцлага хийсэн.

Хүснэгт 2. Асуумжид оролцсон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тус төвд амьдарч буй хугацаа

№	Төвд амьдарч буй хугацаа	Хариулт	%
1	1-6 сар	2	10.5
2	7-12 сар	2	10.5
3	2-4 жил	2	10.5
4	4-8 жил	4	21
5	8-аас дээш жил	6	31.5
Нийт		16	84

АНҮТ-өөр үйлчлүүлж буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 22, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс 17, төвийн бусад ажилтнуудаас 19 асуулт бүхий асуумж авч, мөн тэдгээр асуултуудын хүрээнд ярилцсан байна.

3.3.2.2. АНҮТ-д хийгдсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:

1. АНҮТ-ийг түшиглэн Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хуулийн үйлчлэлд хамаарахгүй хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн тулгамдсан асуудалтай иргэнд асрамжийн үйлчилгээ үзүүлж байна.

Нийгмийн халамжийн тухай хууль /цаашид НХТ хууль гэх/-ийн 19 дүгээр зүйлд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- ахмад настны асрамжийн үйлчилгээ;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ;
- хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээ;
- гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ.

НХТ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээг үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээ, нас, хүйсийн онцлогийг харгалзан нарийвчлан ангилж, төрөлжүүлж

болохоор заасан байх тул ахмад настны асрамжийн үйлчилгээг төрөлжүүлэх хэрэгцээ, шаардлагыг судлах нь зүйтэй байна.

1.1. НХТ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсэгт “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах, ... журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 26.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага асруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хохироосон бол тухайн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргана.” гэж “асруулагч” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна.

Ахмад настнууд НХТ хууль, захиргааны хэм хэмжээний актад тусгагдсан “асруулагч” нэршилд эмзэглэлтэй хандаж улмаар нийгэмд тогтсон сөрөг хандлагаас шалтгаалан гэр бүлийн гишүүд, төрөл, садан, найз нөхөд, ажлын хамт олноос өөрийгөө тусгаарлан харилцаа холбоо тогтоохоос татгалзах, ялангуяа өөрийн нэр төр, алдар хүндийг эрхэмлэн Үндсэн хуульд баталгаажсан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр илэрхийлэхгүй байгаа нь хяналт шинжилгээний явцад дүгнэгдсэн.

Харин НХТ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт "... иргэний хүсэлтийн дагуу төлбөртэй үзүүлж болох бөгөөд тухайн үйлчилгээний төлбөрийн хэмжээг үйлчлүүлэгчтэй хэлэлцэн тогтооно.", 26 дугаар зүйлийн 26.4 хэсэгт "... иргэн, аж ахуйн нэгж, байгууллага асруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хохироосон бол тухайн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргана.", 28 дугаар зүйлийн 28.9.4 дэх заалтын нийгмийн ажилтны эрхэд “мэргэжлийн ёс зүй, эрх, үүрэгт нь болон үйлчлүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах,” тус тус заасан.

НХТ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэг “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тогтоогдсон тэтгэврийнх нь 70 хувийг асруулж байгаа иргэнд, 30 хувийг тухайн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу олгоно.” гэж заасан.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэнийг асруулагч, үйлчлүүлэгч гэж тодорхойлсон боловч НХТ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсэгт “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг... журмыг ... батална.” гэсэн нь энэ хуульд заасан “үйлчлүүлэгч” гэсэн нэр томъёог хэрэглээгүй байна.

Тус төвийн судалгаанд оролцсон ахмад настнууд, ажилтан, албан хаагчид хүнлэг бус, ялгаварлан гадуурхах хандлагатай зохицуулалт гэж дүгнэн НХТ-ийн хуулийн “асруулагч” нэр томъёог хасах талаар санал гаргасан байна.

1.2. НХТ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 19.2.1-19.2.4-т заасан хүүхэд ба иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга гаргана.” гэж заасан.

Хяналт шинжилгээний явцад ахмад настнууд төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага бие даан шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналыг гаргасныг хуульд өөрчлөлт оруулан хүчингүй болгох эсэх асуудлыг судлах нь зүйтэй байна.

2. ХЗХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 3-2/93 дугаартай албан бичигт “... Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн

авах, шилжүүлэх, гаргах журам батлах тухай” А/97 дугаар тушаал нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлгүй байна” гэжээ.

Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.”, 67.3 дахь хэсэг “Энэ хуулийн 67.2-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй.” гэж хуульчилсан байна.

Иймд “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”-ыг НХТ хуулийн үзэл баримтлалын хүрээнд шинэчлэн баталж Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлд заасан шаардлагыг хангах;

Журмын төслийг шинэчлэн боловсруулахдаа холбогдох судалгаа, өнөөгийн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан дараах агуулга бүхий зохицуулалтыг хүний эрхэд суурилсан хандлагад нийцүүлэх талаар зохих арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

2.1. 2013 оны “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”-д НХТ хуульд заасан асрамжийн үйлчилгээний төрлүүдийг дурдах;

2.2. Тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй улмаас дэмжлэг, тусламцаа үзүүлэх чадваргүй иргэнээс 14 төрлийн баримт, мэдээллийг шаардсанаар энэ төвд үйлчлүүлэх иргэдийн эрх хязгаарлагдаж байгааг харгалзан зарим тохиолдолд нийгмийн ажилтан дээрх материалыг бүрдүүлэхээр тусгах;

2.3. “Үйлчлүүлэгч”-ийн хувийн хэргийн нууцлал ба хадгалалтын асуудлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн үзэл баримтлалын дагуу шинэчлэх.

3. Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага /MNS 5823:2016/ стандартад заасны дагуу АНҮТ-ийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний албанд ахмад настны эмч, сэтгэл зүйч, сэргээн засахын эмч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, уламжлалт анагаах ухааны эмч, сэтгэл зүйч, ерөнхий мэргэжлийн сувилагч, эмийн санч, эмнэлгийн тоног, төхөөрөмжийн мэргэжилтнийг ажиллуулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг даруй авах;

4. АНҮТ-ийг түшиглэн Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хуулийн үйлчлэлд хамаарахгүй хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн тулгамдсан асуудалтай иргэнд асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдуулан сэтгэцийн эмч, хэл засалч ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх;

5. Тус төвийн эмч, мэргэжилтнүүд, ажилтнуудтай ажиллах байгууллагын сэтгэл зүйчийн орон тоог бий болгох, тэдэнд зориулсан сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлэх, эсхүл мэргэшсэн сэтгэл зүйчийг тогтмол давтамжтайгаар ажиллуулах эсэх асуудлыг судлан шийдвэрлэх;

6. Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага /MNS 6055:2009/ Явган хүний зам, талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага /MNS 6808:2019/ стандартуудын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдлыг хангах орчныг сайжруулах;

7. Төв аймгийн Батсүмбэр сум, АНҮТ хоорондын зорчих зам нь хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ахмад настныг зөөвөрлөхөд өнөөг хүртэл хүндрэлийг учруулсаар байгаа талаар хяналт шинжилгээний явцад дүгнэгдсэн тул тус замыг засах, сайжруулах

хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон танилцуулгыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээний чанар үр өгөөжийг нэмэгдүүлэх. Тухайлбал, тус төвийн ажилтан, албан хаагчдыг дохионы хэлний сургалтад хамруулах, цахилгаан шатанд харааны бэрхшээлтэй хүнд зориулсан дуут төхөөрөмж, сонсголын бэрхшээлтэй хүнд зориулсан мэдээллийн төхөөрөмж суурилуулахад шаардагдах төсвийг шийдвэрлэх;

9. Сүүлийн жилүүдэд тус төвийн барилгыг өргөтгөх, сувиллын барилга шинээр ашиглалтад оруулах зэргээр ахуй, орчныг сайжруулах ажлууд хийгдсэн байгаа нь сайшаалтай байна.

Гэвч хяналт шинжилгээгээр ХЭҮК-ын гишүүний 2021 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 5/15 тоот албан бичгээр хүргүүлсэн “Шаардлага”-ын 5 дахь хэсэгт тусгагдсан зөрчил таслан зогсоогдоогүйгээс ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зөрчигджээ.

Энэ нь тус төвийн удирдлагын манлайлал, дотоод ажлын зохион байгуулалт, хяналт шалгалт суларсан төдийгүй сургалт, сурталчилгааны ажлын үр нөлөөгүй байдалтай холбоотой гэж асуумж, ярилцлагад оролцогчид дурдсан.

Тухайлбал, Ахмад настны зөвшөөрөлгүй түүний банкны картаар гүйлгээ хийсэн асрагч Т.С-ыг АНҮТ-ийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны дугаар Б/121 тушаалаар 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.3 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн дотоод журам удаа дараа зөрчиж, сахилгын ноцтой зөрчил гаргасан үндэслэлээр үүрэгт ажлаас чөлөөлжээ.

3.3.3.1. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмж:

АНҮТ-д хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн цаашид хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/04 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдад, 08/05 тоот албан бичгээр Эрүүл мэндийн сайдад, 08/07 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад, 08/06 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад, 08/03 тоот албан бичгээр АНҮТ-ийн даргад тус тус хүргүүлсэн.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийн биелэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 02/3059 тоот албан бичгээр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1/5759 тоот албан бичгээр, Зам, тээврийн хөгжлийн дэд сайдын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 02/5305 тоот албан бичгээр, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 2/5585 тоот албан бичгээр, АНҮТ-ийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 238 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн.

3.3.3.2. Зөвлөмжийн биелэлтийг баталгаажуулан ажилласан талаар

ЭШУС хэлтсийн албан хаагчид АНҮТ-д 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалт, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийн биелэлт, хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээг баталгаажуулан ажилласан.

3.4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хийгдсэн хяналт шинжилгээ

ХЭҮК-ын гишүүний 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 3/46 дугаартай “Шаардлага”-ыг СЭМҮТ-ийн захиралд хүргүүлсэн байх бөгөөд уг шаардлагын дагуу хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг гаргаж, хариуг ирүүлсэн байна.⁴¹

Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороонд байрлах СЭМҮТ-ийн ШСЭСК, Асрамжийн тасгуудад хяналт шинжилгээг 2022 оны 8 дугаар сард хийсэн.

3.4.1 Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн үйл ажиллагааны онцлог

СЭМҮТ-ийн ШСЭСК ⁴² нь сэтгэцийн эмгэгийн улмаас Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг үйлдсэн хүнд шүүхийн шийтгэх тогтоолоор эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ/ цаашид ЭЧААХ гэх/-ний хүрээнд албадан эмчилгээ хийдэг буюу сэтгэцийн даамжрах явц бүхий архаг солиорох эмгэгтэй болон хурц солиоролтой эмчлүүлэгчдийг эмчлэх, өндөр мэдлэг, ур чадвар, хурц сонор сэрэмж, тасралтгүй хараа хяналт, харуул хамгаалалт шаарддаг онцлогтой нэгж юм.

СЭМҮТ-ийн шинэ өргөтгөл цогцолборыг 2014 онд ашиглалтад оруулснаар тасгуудын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, ШСЭСК хуучнаар Неврозын тасаг байрлаж байсан байранд шилжин орж зай, талбай нэмэгдэж, эмч, ажилчид, эмчилгээний орчин сайжирсан боловч гэмт хэрэг, зөрчлийн хэргээр эмнэлгийн чанартай албадан эмчилгээ хийлгэж байгаа

⁴¹ СЭМҮТ-ийн захирлын 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр 1/102 дугаартай албан бичиг.

⁴² Тус клиникийн тайланд дурдсанаар батлагдсан орон тоогоор 16 ажилтантай бөгөөд тасгийн эрхлэгч эмч 1, эмчлэгч эмч 3, ахлах сувилагч 1, сувилагч 5, туслах сувилагч 5, бичиг хэргийн ажилтан 1 ажиллаж байна.

эрэгтэй, эмэгтэй, өсвөр насны эмчлүүлэгчдийг нэг дор, нэг жигүүрт, тусгаарлах хаалгагүй тасалгаанд байрлуулан, албадан эмчилж байна.

2022 оны 8 дугаар сарын 24-ны байдлаар шүүхийн шийтгэх тогтоолоор албадан эмчлүүлж байгаа эрэгтэй 24, эмэгтэй 14, нийт 38 хүн байна. Үүнээс:

- шүүхээс ЭЧААХ-ний тогтоосон хугацаандаа байгаа 18,
- шүүхээс ЭЧААХ-ний хугацаа заагаагүй 13,
- шүүхээс ЭЧААХ-ний тогтоосон хугацаа дууссан 7 хүн албадан эмчлүүлж байна.

Эмчлүүлэгчийн талаар бүртгэл судалгаа⁴³нд гэр бүлийн гишүүний зүгээс асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүргээс татгалзах хүсэлт гаргасан 11, гэр бүлийн гишүү, төрөл, садан байхгүй 2 гэж дурджээ.

2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвийн харуул, хамгаалалтын алба хаагчид тус клиникт 3 ээлжээр ажиллаж байгаа бөгөөд нэг ээлжид 2 харуул хамгаалалтын ажилтан 24, 48 цагаар, ажлын өдрүүдэд тус клиникт харуул хамгаалалтын ахлах байцаагч 9 цагаар (08:30-17:30) тогтмол үүрэг гүйцэтгэдэг байна.

Мөн өрөө тасалгааг бүрэн камержуулж, нийт 36 камерын дэлгэцээр өдөр тутмын үйл ажиллагааг бүрэн тасралтгүй хянах, эмчлүүлэгчдийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

3.4.1 Асрамжийн тасгийн онцлог


СЭМҮТ-ийн Асрамжийн 1,2 дугаар тасаг нь шүүхийн шийдвэрээр бус тэдгээрийн хүсэлт сайн дурын үндсэн дээр сэтгэцийн эмгэг болон тулгамдсан асуудалтай иргэдэд хуульд заасан эмчилгээ үзүүлдэг байнгын болон түр оршин суух нөхцөлийг ханган үйл ажиллагаа явуулдаг.



СЭМҮТ-ийн Асрамжийн 1,2 дугаар тасгуудын үйл ажиллагаатай танилцаж эмчлүүлэгчдээс асуумжид оролцсон 13 хүнээс “Энэ байгууллагын нөхцөл ямар вэ?” гэсэн асуултад 5 буюу 55.5 % нь “сайн”, 4 буюу 44.4 % нь “дунд” гэж хариулжээ.

⁴³ Тус клиникт албадан эмчлүүлж байгаа 38 өвчтөний хувийн хэргийн иж бүрдэл зохих журмын дагуу бүрдүүлж, хөтөлсөн байсан.

“Танд энэ байгууллагын дотоод журмыг танилцуулсан уу?” гэсэн асуултад асуумжид оролцсон 9 эмчлүүлэгчдээс 8 буюу 88.8 % нь “тийм”, 1 буюу 11.1 % нь “үгүй” гэж хариулсан тэдгээрийн сэтгэл зүйн онцлогтой холбоотой байж болох ч дотоод журмыг танилцуулж мөрдөж ажилладаг байна.



“Та өдөр тутам голчлон юу хийдэг вэ?” гэсэн асуултад асрамжийн клиникийн эмчлүүлэгчдээс “гэр цэвэрлэх” гэж 1 буюу 7.6 %, “зурагт үзэх” гэж 2 буюу 15.2 %, “ус зөөх” гэж 3 буюу 23%, “модоо услах” гэж 4 буюу 30.7 %, сэтгэц эмгэг судлалын клиникт албадан эмчлүүлэгчдээс 1 хүн зурагт үзэх, 2 хүн дасгал хийх гэж хариулжээ. /график 3/

3.4.3. Хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал

1. 2015 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагыг ял, албадлагын арга хэмжээ гэж тодорхойлон албадлагын арга хэмжээний төрөлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хуульчилж гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд тухайн хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахаар бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ гэж заажээ.

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй хүн өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй, харин гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүх түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, эдгэрсний дараа ял оногдуулдаг.

2015 оны Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, согтуурах, мансуурах донтой байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.” гэж эмчилгээний 2 төрлөөр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр зохицуулсан.

Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.” гэж заасан боловч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, ЭХХШТ болон ШШГТ хуулиуд, захиргааны хэм хэмжээний актад эмнэлгийн чанартай албадлагын арга

хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь мөрдөгч, прокуророос шинжээч томилсон тогтоолд асуулт тавигддаггүй, шинжээчийн дүгнэлтэд тусгагддаггүй, шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй нөхцөл байдал хяналт шинжилгээний явцад тогтоогдлоо.

1. ЭХХШТ хуулийн 19.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлт гаргахад яллагдагчийг тодорхой хугацаанд эмнэлэгт хэвтүүлж, эмчийн хяналтад байлгаж, ажиглалт хийх шаардлагатай тохиолдолд шүүх нь шинжээчийн саналыг үндэслэн яллагдагчийг эмнэлэгт хэвтүүлж, эмчийн хяналтад байлгах тухай шийдвэр гаргана.”, энэ зүйлийн 5 дахь хэсэгт “... эмнэлэгт хэвтүүлж, эмчийн хяналтад байсан хугацааг цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно” гэж заасан.

Энэхүү эрх зүйн зохицуулалтын хүрээнд яллагдагчийг СЭМҮТ-ийн ШСЭСК-т эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчидтэй хамт эмчийн хяналтад байлгаж, дүгнэлт гаргасан тохиолдол бүртгэгдсэн бөгөөд ХЗДХ-ийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны Дугаар А-240/369 хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-д энэхүү агуулга тусгагдаагүй байна.

2. Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 2022/3Ш/563 дугаартай шийтгэврээр Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан /Бэлгийн дарамт учруулах/ зөрчилд холбогдуулан Б.Б-г Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн 2.3 дахь хэсэгт заасныг баримтлан мөн хуулийн тусгай ангийн 6.26 дугаар зүйлийн 1-т заасан шийтгэлийг оногдуулахгүйгээр чөлөөлж, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг 3 сарын хугацаагаар оногдуулсан.

Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Зөрчил үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд шийтгэл оногдуулахгүйгээр хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.” гэж заасныг үндэслэн Б.Б-д оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг ШСЭСК-т эдлүүлэн, хугацааг дуусгажээ.

Энэхүү шүүхийн шийдвэрээр зөрчил үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлагын нэг төрөл албадлагын арга хэмжээний эмнэлгийн чанартай албадлагыг хэрэглэсэн нь Эрүүгийн хуульд заасан Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх хууль ёсны зарчмыг зөрчжээ.

ШШГТ хуулийн 190 дүгээр зүйлийн 190.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана.” гэж заасан.

Түүнчлэн ХЗДХ-ийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн дугаар А-240/369 хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын 1.2-т “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих үндэслэл нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоол, магадлал байна” гэж журамласан.

Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчдийг хамт эмчилж байгаа нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчжээ.

3. 2015 оны Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга

хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргана.”, энэ зүйлийн 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно.” гэж тус тус заасан.

ЭЧААХ авагдсан эмчлүүлэгчийн шүүхийн тогтоолд тусгагдсан хугацаа дуусгавар болсон эсхүл 2002 оны Эрүүгийн хуульд зааснаар хугацаа тогтоохгүйгээр ЭЧААХ авагдсан эмчлүүлэгчийг хуульд зааснаар энэхүү арга хэмжээг зогсоосон тохиолдолд гэр бүлийн гишүүн, төрөл, садан, асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй эсхүл тэдгээр нь хүлээн авахаас татгалзсаны улмаас ШСЭСК-т албадан эмчилгээг үргэлжлүүлэн хийж байгаа нь ХЗДХ-ийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны Дугаар А-240/369 хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын 4.8 буюу “Асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь холбогдох байгууллагад хүсэлтээ гарган асуудлыг шийдвэрлэж ажиллана” гэсэн зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй байгаа нь тогтоогдлоо.

Энэ нь ЭЧААХ хэрэглэх хугацаа дууссан эмчлүүлэгчид шүүхийн тогтоолгүйгээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэглэж, тухайн эмчлүүлэгчид бүх насаар нь албадан эмчилгээ хийх нөхцөл байдал үүссэн байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад “Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.” гэж заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг ноцтой зөрчиж байна.

4. Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.” гэж заасан.

5. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 3-2/93 дугаартай албан бичигт “... ХЗДХ-ийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны “ Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам батлах тухай” А-240/369 хамтарсан тушаал, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам батлах тухай” А/97 дугаар тушаал нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлгүй байна” гэжээ.

6. СЭМҮТ-ийн захиралд хүргүүлсэн “Асруулагчдын нийгмийн халамжийн тэтгэмжийн зарцуулалтад хяналт, шалгалт хийх, цаашид хяналт тавих горим бий болгох”, “Нэг оронд хоёр хүн хэвтэн эмчлүүлэх байдлыг таслан зогсоох” талаар ХЭҮК-ын гишүүний 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 3/46 дугаартай “Шаардлага” биелэгдээгүй байна.

7. ШСЭСК-т шүүхийн шийдвэрээр эмнэлгийн чанартай албадан эмчилгээ хийлгэж байгаа эрэгтэй, эмэгтэй, өсвөр насны эмчлүүлэгчид болон сэтгэц эмгэг судлалын шинжилгээ хийлгэж байгаа хүнийг нэг дор, нэг жигүүрт, тусгаарлах хаалгагүй тасалгаанд байрлуулсан, албадан эмчилж байгаа нь сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчид, эмч, эмнэлгийн ажилтнуудын амь нас, эрүүл мэнд, аюултай байдалд орж болзошгүй эрсдэлтэй нөхцөл үүссэн.

8. Эмч, эмнэлгийн ажилтнуудтай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаар дараах нөхцөл байдал дурдагдсан. Үүнд:

- ажлын ачаалал маш их, хэт ачаалалтай олон цагаар ажилладаг, ажлын байрны тодорхойлолтод зааснаас өөр ажил үүрэг гүйцэтгэдэг;
- нийгмийн ажилтан шаардлагатай, харуул, хамгаалалтын ажилтан хүрэлцдэггүй;
- ажил үүрэгтэй холбоотой ямар нэг халдлагад өртөх, эрүүл мэндээрээ хохирдог, эмчлүүлэгчдээс хэл амаар доромжилдог;
- тус клиникийн эмч, эмнэлгийн ажилтнуудад сэргээн засах, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг байгууллагын зүгээс хэрэгжүүлдэггүй;
- албадан эмчлүүлэгчид гэнэтийн огцом авир гаргаж өөртөө болон бусдад хохирол учруулах эрсдэлтэй байдаг тул байнгын анхаарал болгоомжтой ажиллах шаардлага тулгарч сэтгэл зүйн хувьд айдас, түгшүүртэй байдаг;
- аливаа хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх сэдвээр сургалтад ажилчдыг хамруулах;
- энэ тасагт ажилласнаар ямар нэгэн нэмэгдэл хөлс авдаггүй, ажилтнуудын нийгмийн асуудалд дорвитой өөрчлөлт оруулах.

Тохиолдол

... Ер нь манай тасагт ажиллаж байгаа ажилтнууд болон өвчтөнүүд “Мартагдсан арлын орхигдсон хүмүүс”бидний Монгол Улсын Үндсэн хууль, хуульд баталгаажуулагдсан эрхийг хангах, хамгаалах эрх бүхий албан тушаалтнууд анхааралдаа авах байх гэж олон жил хүсэн хүлээж байна.....

(СЭМҮТ-ийн ШСЭСК-ийн эмчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

9. Эмэгтэй албадан эмчлүүлэгчдийн биед нь үзлэг хийх, өвчний учраас нарийн мэргэжлийн эмчид хандаж клиникээс бусад газар үзлэг, оношилгоо хийлгэх, шинжилгээ өгөх, хэвтэн эмчлүүлэх тохиолдолд ижил хүйсийн харуул хамгаалалтын ажилтангүй, түүнчлэн харуул хамгаалалтын алба хаагчид, ШСЭСК-ийн эрэгтэй, эмэгтэй ажилтнууд хамтдаа нэг өрөөнд хувцсаа сольдог байдал нь Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээ бий болгоход чиглэсэн арга хэмжээ авна” гэж заасан Эрүүл мэндийн салбар дахь Жендерийн эрх тэгш байдлын баталгааг зөрчжээ.

ШСЭСК-т харуул хамгаалалтын албан үүрэг гүйцэтгэж байсан хамгаалалтын ажилтан ахлагч О.Б нь 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 08 цагийн орчим албадан эмчлүүлэгч Г.О-г тавьсан шаардлагыг биелүүлсэнгүй гэх шалтгаанаар алгадаж зүүн шанаа орчимд улайлт, баруун нүдэнд хөхрөлт үүсгэн гэмтэл учруулсан нь ШШГЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүн дэд даргаас ирүүлсэн 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 02/1709 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг, Баривчлах төвийн даргын 2022 оны 08 дугаар сарын 2-ны өдрийн Б/07 дугаартай “О.Б-д сахилгын шийтгэл оногдуулах тухай” тушаал, Баривчлах төвийн харуул, хамгаалалтын ахлах байцаагчийн “Зөрчил шалгасан талаарх” илтгэх хуудсаар тогтоогджээ.

3.3.1.4. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмж:

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/02 тоот албан бичгээр СЭМҮТ-ийн захиралд, 08/05 тоот албан бичгээр Эрүүл мэндийн сайдад, 08/07 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлын биелэлтийн хариуг хуульд заасан хугацаанд албан бичгээр ирүүлсэн бөгөөд Зөвлөмжид

дурдагдсан 1 агуулга бүрд 1-15, нийт 37 арга хэмжээг төлөвлөж хугацаа, хариуцах албан тушаалтан, хүрэх түвшин, биелэлтийг арга хэмжээ бүрд тайлагнаж ирүүлсэн.

2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/05 дугаартай албан бичгээр ЗГ-ын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хүргүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлын биелэлтийн хариуг хуульд заасан хугацаанд албан бичгээр ирүүлсэн.

Харин 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1/5759 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын албан бичигт дараах агуулга тусгагдсан нь онцгой анхаарал татаж байна. Үүнд:

“ 2. Зөвлөмжийн 4 дүгээрт заасан асуудлаар Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, түүнд тавих прокурорын хяналт, нийгмийн хэв журмыг сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа “ нь мөн хуулийн үйлчлэлд хамаарахгүй байх зохицуулалттайг анхаарч цаашид зөвлөмж боловсруулахдаа хууль тогтоомжийг сайтар судалж байх нь зүйтэй байна”

3. Зөвлөмжийн 5 дугаарт заасан асуудлаар актыг батлан гаргасан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу актыг хянаж, бүртгэх чиг үүрэгтэй байх ба татан хянах үүрэг хүлээгээгүй тул тухайн асуудлаар эрхлэх сайдад нь хандахыг анхаарна уу.” гэжээ.

Энэ нь 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүйд тооцогдсон Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 хэсэгт “Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т зааснаас бусад захиргааны үйл ажиллагаатай холбогдсон харилцаанд энэ хууль үйлчилнэ.” гэж зохицуулж байсан.

Улмаар Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар дээрх 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хүчингүйд тооцож энэ хуулийн 3 зүйлийн 3.4 хэсэгт “Захиргааны байгууллагын үйл ажиллагааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж хуульчилсан нь Захиргааны ерөнхий хуульд заасан энэхүү хуулийн үйлчлэлд хамаарахгүй байгууллагын захиргааны хэм хэмжээний акт хуулийн үйлчлэлийг дагаж мөрдөнө гэсэн агуулгатай юм.

Иймээс эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангах, хамгаалах нь тухайн хүний мэдэх эрхийг хангахаас улбаатай учраас Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх захиргааны хэм хэмжээний актуудыг хуулийн шаардлагыг хангуулах үүргээ холбогдох албан тушаалтнууд биелүүлэх нь зүйтэй байна.

ДӨРӨВ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

4.1. ЭШУС сургалтын чиглэлээр

ЭШУС Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмж⁴⁴-д “25. ... Түүнчлэн эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах асуудлыг мөрдөн шалгах, баримтжуулан тогтоохтой холбоотой ажил үүрэг, үүрэг хүлээдэг шүүгч, прокурор, эрүүл мэндийн ажилтнууд, болон энэ салбарт хамаарах ажил хийдэг бусад албан хаагчдыг Истанбулын протокол, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах үйлдлийг зогсоох, тэдгээр үйлдлүүдийг ялгах, ангилах, тусгайлсан эрүүл мэндийн үзлэг хийх зэрэг олон улсын стандартын тухай зохих сургалтад хамруулах боломжоор Оролцогч улс хангах ёстой...” гэжээ.

ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл⁴⁵-ийн Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар өгч буй саналд “3.ЭШЭК болон бусад олон улсын гэрээнд заасан эрүү шүүлтээс ангид байх эрхийн мэдлэг, ойлголтыг мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, албан хаагчдад олгож, үйл ажиллагааны нэг үндсэн зарчим болгож, дадал эзэмшүүлэх” талаар дурдсан байна.

Тайлангийн хугацаанд прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, АНҮТ-ийн албан хаагчид, Нийгмийн хамгааллын салбарын төрөлжсөн асрамжийн ажилтнууд, СЭМҮТ-ийн ажилтнууд зэрэг нийт 3357 албан тушаалтан, ажилтан, алба хаагчдад дараах сэдвээр сургалт, хэлэлцүүлэг явуулсан байна.⁴⁶ Тухайлбал,

- ШШГЕГ-ын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 01/794, ШШГЕГ-ын Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 1/20 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн хүсэлтийн дагуу уг байгууллагуудад “ЭШУС үндэсний ажиллагааны танилцуулга”, “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангах асуудал”, “Олон улсын гэрээ конвенцод тусгагдсан эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх”, “Харилцаа ба сэтгэл хөдлөл” сэдвээр;

- Нийслэлийн цагдаагийн удирдах газрын албадан саатуулах болон баривчлах төвийн алба хаагчид болон ХЭҮК-ын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүдэд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга”, “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангах асуудал” сэдвээр;

- Чингэлтэй дүүргийн Прокурорын газартай хамтран эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хамгаалах, ялангуяа Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, саатуулах, ялгаварлан гадуурхах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, алба хаагчдыг чадавхжуулах зорилгоор “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, “ЭШУС үндэсний ажиллагааны танилцуулга”, “Эрүү шүүлтийн эсрэг конвенц, түүний нэмэлт протоколын хэрэгжилтийн зарим асуудал” сэдвээр;

- Нийслэлийн цагдаагийн удирдах газраас зохион байгуулсан “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж биеэ авч явах чадваргүй иргэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж,

⁴⁴ Хүний эрхийн Үндэсний Комисс, НҮБ-ын Монгол Улс дахь Суурин зохицуулагчийн газар “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс эмхэтгэл”, 2021 он, УБ Хоёрдугаар боть, 443 дахь тал /Албан ёсны бөгөөд засваргүй тус баримт бичиг болно./

⁴⁵ <https://nhrcm.gov.mn>

⁴⁶ Хавсралтаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

үйлчилгээг сайжруулах нь” хэлэлцүүлэгт “Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх, түр саатуулах байранд хүний эрхийг хангах асуудал” сэдвээр;

- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Цагдаагийн газраас зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдад зориулан зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь” сургалт, хэлэлцүүлэгт “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь” сэдвээр тус тус сургалт явуулсан байна.

Зарим байгууллага сургалтын хөтөлбөртөө эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг тусган зохион байгуулсныг эс тооцвол хууль сахиулах байгууллагын давтан сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, сургалтыг тогтмолжуулах заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Манай улсын тухайд эрүүдэн шүүх асуудлаар хуульч, хууль сахиулагчдыг сургах чиглэлээр алхмууд авч хэрэгжүүлдэг ч бусад мэргэжилтэн, тухайлбал, эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, асрамж, халамжийн газрын ажилтнууд, цэргийн анги нэгтгэлийн алба хаагчдад энэ чиглэлийн сургалт зохион байгуулах ажил сул байна.⁴⁷

Сургалтын хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах, хуульч, хууль сахиулагчдаас гадна эмнэлгийн мэргэжилтэн, бусад холбогдох ажилтнуудыг сургахад анхаарах, мөн сургалтын чанарт хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх санал⁴⁸-ыг дэмжиж энэхүү чиглэлд анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

4.2. ЭШУС сурталчилгааны чиглэлээр

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т “Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах;” 33.1.3-т “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах;” 33.1.4-т “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах” гэж тус тус заасан.

4.2.1. Үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг олон нийтэд сурталчлах талаар

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон түүнд туслах чиг үүрэг бүхий нэгжийн үйл ажиллагаа, хяналт шинжилгээ, сургалт, хэлэлцүүлэг үйл ажиллагааны тухай 32 удаагийн мэдээ, мэдээллийг бэлтгэн ХЭҮК-ын цахим хуудас болон хандалт ихтэй мэдээ, мэдээллийн сайтуудаар болон цахим орчинд олон нийтэд түгээв.

Иргэдэд ЭШЭК-ын талаар таниулан сурталчлах, түгээх зорилгоор олон нийтийн сүлжээнд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” цахим хуудсыг 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс нээн ажиллуулж, одоогоор 1000 гаруй дагагчтай болоод байна.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр “Ийгл” телевизийн зочны цагаар, 2022 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Ийгл” телевиз, Зариг.мн сайтад ЭШЭК түүний Нэмэлт протоколын талаар мэдээлэл өгөв.

⁴⁷ “Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцаанаас ангид байх эрхийн хэрэгжилт” (Монгол Улсын Хүний эрхийн ТББ-уудын форум. 2019.10.03).

⁴⁸ Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл /тойм судалгаа/ Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэн 2021, УБ., 31 дэх тал.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн Зууны мэдээ сонинд “Мэдүүлэг авахдаа хүлээлгэх, албадах нь эрүү шүүлтийн хэлбэр” сэдвээр ярилцлага өгөв.

НҮБ-аас 1984 онд баталсан ЭШЭК-ын танилцуулга хуудсыг 2023 оны 01 дүгээр сарын 10-наас 02 дугаар сарын 08 хүртэл 30 хоногийн турш ЭШУС үндэсний ажиллагааны цахим хуудсанд нийтэлж, олон нийтэд түгээсэн.

4.2.2. ЭШУС үндэсний ажиллагааны сурталчилгааны хэрэглэгдэхүүн

ЭШЭК-ын Нэмэлт протоколыг таниулан сурталчлах, улмаар ЭШУС үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалт шинэчлэлтийг олон нийтэд сурталчлах зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 30-нд 10-15 минутын танилцуулга, видео бэлтгэх зөвлөх үйлчилгээний зарыг олон нийтэд түгээж “Сартпланет ХХК”-тай гэрээ байгуулан 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр танилцуулга видеог хүлээн авч түгээж байна.

Тухайлбал, Танилцуулга видео танилцуулгыг, МҮОНТ, UBS, ТВ5, ТВ6, ТВ8, ТВ9, 25-р суваг, Стар, Малчин, Парламент, NTV, C1, Монгол, Боловсрол телевизүүдээр дамжуулан олон нийтэд 2-3 удаагийн давтамжтай хүргэсэн.

ЭШУС хэлтэс нь хяналт шинжилгээ явуулах албан хаагчдад болон хяналт шинжилгээ явуулах байгууллага, нэгжийн удирдлага, албан хаагч, иргэдэд зориулж дараах гарын авлагуудыг зөвлөх үйлчилгээгээр боловсруулж хэвлэлтэд бэлтгэжээ. Үүнд:

- “Аливаа хэлбэрээр хүүхдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн хүүхэд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй төрийн болон төрийн бус байгууллагад хийх хяналт шинжилгээ”,

- “Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх сэтгэцийн тулгамдсан асуудалтай болон сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах төрийн албан хаагч, хуулийн этгээд, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эмнэлгийн мэргэжилтний үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагаанд хийх мониторинг”

Тус хэрэглэгдэхүүн нь сургалтад ашиглахын хүрээнд дохионы хэлний хэлмэрч, англи хэл рүү субтитрт орчуулгатай бэлтгэгдсэн байна.

ТАВ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

5.1. Олон улсын байгууллагатай хамтран ажилласан талаар

5.1.1. НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.8 дахь заалтаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх” бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага, механизм нь /цаашид ҮУСБ гэх/ байгуулагдсанахаа дараа НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо /цаашид ЭШУС Дэд хороо гэх/-той шууд холбоо тогтоож, нэн тэргүүнд харилцах ёстойг ЭШЭК-ын Нэмэлт протоколын 11 (b) заалтад⁴⁹ тусгасны дагуу тус Дэд хороотой нягт холбоотой ажиллаж байна.

НҮБ-ын ЭШУС Дэд хороо нь 2006 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байгуулагдсан бөгөөд 25 гишүүнтэй, НҮБ-ын гэрээний хороод дотор хамгийн өргөн бүрэлдэхүүнтэй бүтэц юм.

ЭШУС Дэд хороо нь ЭШЭК-ын Нэмэлт протоколын оролцогч улсуудын ЭШУС үндэсний ажиллагааны чадавхыг сайжруулах, зөвлөмж өгөх болон оролцогч улсуудад айлчилж, эрх чөлөөг хязгаарлах газруудад хяналт шинжилгээ хийх гэсэн үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.

Үйл ажиллагаагаа шинэ тутамд эхлүүлсэн ҮУСБ-ууд юуны өмнө Дэд хорооноос зөвлөн туслах чиг үүргийнх нь хүрээнд чадавхжих, бүрэн эрхээ бэхжүүлэхэд чиглэсэн техник, аргазүйн сургалт, зөвлөгөө авах, ЭШУС үйл ажиллагааг үр дүнтэй явуулах арга, хэрэгцээгээ тодорхойлоход зөвлөгөө, тусламж авах эрх олгогдсон байдаг.

Үүний дагуу ЭШЭК-ын Нэмэлт протокол болон олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааг үр нөлөөтэй, бодитой, хүртээмжтэй зохион байгуулахад нэгжийн албан хаагчдыг чадавхжуулах, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэхээр НҮБ-ын ЭШУС Дэд хороотой хамтран ажиллаж эхлээд байна.

ЭШУС Дэд хороо нь ЭШЭК-ын Нэмэлт протоколд нэгдэн орсон оролцогч улсуудад айлчилж, хяналт шинжилгээ явуулах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг бөгөөд 2017 оны 09 дүгээр сарын 11-20-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны ажлын айлчлал хийж, айлчлалын хүрээнд олж авсан мэдээлэл, дүгнэлт дээрээ үндэслэн Монгол Улсад хандан Зөвлөмж⁵⁰ хүргүүлсэн билээ.

ЭШУС үндэсний ажиллагааны чиг үүргийнхээ хүрээнд Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаагаа ЭШЭК-ын Нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн явуулахад анхааран ажиллаж, бүс нутгийн болон олон улсын сүлжээ байгууллагатай олон талт түншлэлийг хөгжүүлэх, ҮУСБ-уудын бүсийн уулзалтад оролцох, ялангуяа хүний эрх чөлөө хязгаарлагдсан газруудад хяналт тавих аргачлалын талаар туршлага солилцоход чиглэсэн олон улсын уулзалт, үйл ажиллагаануудад идэвхтэй оролцох бодлогыг баримталж байна. Тухайлбал:

- 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр НҮБ-ын ЭШУС Дэд хорооны Ази Номхон далайн бүсийн төлөөлөгчид ЭШУС хэлтсийн албан хаагчидтай цахим уулзалт зохион

⁴⁹ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийн доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. Зүйл 11.

⁵⁰<https://docstore.ohchr.org/>

байгуулж, Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, нэгжийн чиг үүрэг, албан хаагчдын мэдлэг, туршлага, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, ЭШУС ажиллагаанд гарч буй тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал солилцов.⁵¹

- ЭШЭК-ын Нэмэлт протокол батлагдсаны 20, НҮБ-ын ЭШУС Дэд хороо байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээ 2023 оны 02 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд Швейцарын Холбооны Улсын Женев хотноо зохион байгуулагдаж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн биечлэн оролцлоо. Энэхүү арга хэмжээ нь Нэмэлт протоколд нэгдэн орсон оролцогч улсуудын ЭШУС үндэсний ажиллагааны ололт амжилт, тулгамдаж буй асуудлуудын талаар санал бодлоо солилцох, Нэмэлт протоколыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд улс орнуудын Үндэсний ажиллагаанууд сайн туршлагаасаа хуваалцах, цаашид хамтран ажиллах боломжийг олгох, мөн ирээдүйгээ тодорхойлоход чиглэгдэх зорилготой байлаа.

НҮБ-ын ЭШУС Дэд хорооны Дэд дарга, илтгэгч, хатагтай Мариа Льюса Ромеро болон Дэд хорооны гишүүн Массимилиано Багаглини, Монгол Улсыг хариуцсан гишүүн Ника Кварачкелиа нартай ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн уулзаж, ЭШУС мандатыг хэрэгжүүлж буй явц, ололт амжилт, тулгарч буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, цаашдын зорилгоо танилцуулж, Дэд хороо болон бусад улсын ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажиллах, ЭШУС үндэсний ажиллагааныхаа чадавхыг бэхжүүлэх, туршлага солилцох талаар бодитой үр дүнд хүрсэн уулзалт хийлээ.

НҮБ-ын Женев дэх Байнгын Төлөөлөгч, Швейцарын Холбооны Улсад суугаа Элчин сайд Д.Гэрэлмаа Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж уг арга хэмжээнд үг хэлсэн бөгөөд Монгол Улсын ЭШУС чиглэлээр баримталж байгаа бодлого, стратеги болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний үр нөлөөг цаашид хэрхэн сайжруулах арга зам, бодлогыг дурдаж, цаашид ЭШУС Дэд хороо, бусад ОУБ-уудтай хамтын ажиллагааг улам өргөжүүлж байгаа талаар танилцууллаа.

Тэрээр Монгол Улсын Засгийн газрын зүгээс ЭШУС үндэсний ажиллагааг улам чадавхжуулах, бэхжүүлэхэд анхаарч, бие даасан, хараат бус байдлыг хангах, хууль эрх зүйн орчныг сайжруулахад дэмжин ажиллахаар зорьж байгаа тухай илтгэлдээ дурдсан юм⁵².

- НҮБ-ын ЭШУС Дэд хороо нь Нэмэлт протоколд оролцогч улсуудын үүрэг хариуцлагын хүрээнд ЭШУС үндэсний байгууллагууд болон бусад оролцогч талуудад тулгарч болох асуудлуудыг тодорхойлох, шийдвэрлэх зорилгоор ЭШЭК-ын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйлийн талаар ерөнхий тайлбар бэлтгэж байгаа бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 5-16-ны хооронд болох ЭШУС Дэд хорооны 50 дугаар чуулганы үеэр уг тайлбарын хүрээнд олон нийтийн нэгдсэн хэлэлцүүлэг өрнүүлэх юм.

Нэмэлт протоколын оролцогч улсууд, ҮҮСБ-ууд чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа олж авсан туршлага, дүгнэлт дээр үндэслэн Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл дээр тайлбар боловсруулж, уг хэлэлцүүлэгт оролцох боломжийг олгосны дагуу ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн холбогдох тайлбар боловсруулан НҮБ-ын ЭШУС Дэд хороонд илгээхээр ажиллаж байна⁵³.

Цаашид Монгол Улс НҮБ-ын ЭШУС Дэд хорооны гишүүний сонгон шалгаруулалтад зохих шалгуурыг хангасан Монгол Улсын иргэний нэрийг дэвшүүлэн өрсөлдүүлэх бүрэн

⁵¹ ХЭҮК-ын ЭШУС хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангаас.

⁵² Public Meeting, 49th Session, Subcommittee on Prevention of Torture (SPT) | UN Web TV

⁵³ OHCHR | Call for comments on the draft general comment of the Subcommittee on Prevention of Torture (SPT) on the article 4 of the OPCAT (optional protocol to the convention against torture)

боломжтой бөгөөд энэ нь Ази, номхон далайн бүсийн орнуудад ҮУСМ-ыг бэхжүүлэх, сурталчлах чиглэлээр тэргүүлэх чиглэлээр ажиллах боломжтой байна.

5.1.2. НҮБ-ын Хүний эрхийн бусад механизмтай хамтран ажиллах талаар:

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүнд туслах үүрэг бүхий ЭШУС хэлтэс нь НҮБ-ын ЭШУС Дэд хороотой хамтран ажиллахаас гадна НҮБ-ын хүний эрхийн тогтолцоонд хамаарах бусад байгууллагатай уялдаатай ажиллахаар төлөвлөөд байна.

Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настнууд, бэлгийн цөөнх иргэд зэрэг бүлгийнхний эрүү шүүлтээс ангид байх эрхийн баталгааг бүрдүүлэх хүрээнд НҮБ-ын гэрээний болон дүрмийн механизмтай ойр ажиллах шаардлага үүсдэг. Энэ хүрээнд:

- 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр ХЭҮК, Ази Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулгантай хийсэн цахим Дээд хэмжээний уулзалтад ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн оролцож, ЭШУС үндэсний ажиллагааг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах зэрэг асуудлаар хэлэлцүүлэгт өөрийн байр сууриа илэрхийлж, санал бодлоо солилцов⁵⁴.

- Дур зоргоор баривчлан саатуулах асуудал хариуцсан НҮБ-ын Ажлын хэсэг⁵⁵ 2022 оны 10 дугаар сарын 03-14-ний өдрүүдэд манай улсад албан ёсны айлчлал хийхэд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, ЭШУС хэлтсийн албан хаагчид уулзалт, ярилцлага хийсэн.⁵⁶

Ажлын хэсэг хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, өөрийн хүслээр орхин гарах боломжгүй газруудад ажиллаж, үнэлгээ хийж, гаргасан дүгнэлтэд ЭШУС үндэсний ажиллагааны агуулга тусгагдсан бөгөөд ЭШУС үндэсний ажиллагааны бие даан, үр дүнтэй хэрэгжүүлэх чадамжийг бэхжүүлэх, үүний тулд санхүүгийн эх үүсвэрийг цаашид нэмэгдүүлэх, эрх чөлөөгөө хасуулсан газруудад гэнэтийн шалгалт хийх бүрэн эрхэд нь зайлшгүй шаардагдах санхүүгийн хараат бус байдлыг баталгаажуулах, ялангуяа гэнэтийн шалгалт хийх бүрэн бололцоо, чадвартай болгохыг Засгийн газарт уриалав. Түүнчлэн хэлтсийн албан хаагчдыг зохист хэмжээнд хүргэх, боловсон хүчнээ сонгохдоо бие даасан байдлыг хангаж өгөхийг уриалсан юм⁵⁷.

- НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар болон Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Дэлхийн Холбоо, Украйны парламентын Хүний эрхийн Комисс, Дани улсын Хүний эрхийн Хүрээлэн хамтран 2023 оны 11 дүгээр сард зохион байгуулах “Эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцахтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд Хүний эрхийн үндэсний байгууллагуудын үүрэг” сэдэвт олон улсын 14 дүгээр бага хурал⁵⁸-ын урьдчилсан цахим хэлэлцүүлэгт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн оролцов.

⁵⁴ Ази Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулгантай Дээд хэмжээний уулзалтыг цахимаар зохион байгууллаа - Хүний эрхийн Үндэсний Комисс (nhrcm.gov.mn)

⁵⁵ WGAD_Mongolia_PR-29Sep2022_Mongolian.pdf (ohchr.org): Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийг бусдын эрх чөлөөг үндэслэлгүй, дур зоргын үндсэн дээр хассан гэх хэрэг маргааныг шалгах зорилгоор 1991 онд байгуулагджээ. Ажлын хэсэг нь Хүний эрхийн Зөвлөлийн Тусгай журам /Special Procedures/ хэмээн нэрлэгддэг механизмд хамаардаг бөгөөд НҮБ-ын Хүний эрхийн тогтолцооны хамгийн олон хараат бус шинжээчдийг өөртөө нэгтгэж, улс орнуудын нөхцөл байдал эсхүл тодорхой сэдэвчилсэн асуудлаар хараат бусаар баримт цуглуулах, хяналт үнэлгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

⁵⁶ ХЭҮК НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх ажлын хэсгийн гишүүдтэй санал солилцлоо - (nhrcm.gov.mn) Хүний эрхийн Үндэсний Комисс

⁵⁷ UN's Working group on Arbitrary Detention: Preliminary Findings from its visit to Mongolia (3 to 14 October 2022)

⁵⁸ 14th International Conference - GANHRI

Уг олон улсын бага хурал нь ЭШЭК-ын Нэмэлт протоколд нэгдэн орсон оролцогч талуудын Хүний эрхийн үндэсний болон ЭШУС байгууллагуудын шилдэг туршлага, шинэ арга барил, хамтын ажиллагааг тодорхойлоход чиглэгдсэн.

Цахимаар зохион байгуулагдсан уг урьдчилсан хэлэлцүүлэгт ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс ЭШУС Дэд хорооны Монгол Улсад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, хамтран ажиллах, олон улсын сайн туршлагаас суралцах, практикт нэвтрүүлэх, бүс нутгийн болон олон улсын сүлжээ байгууллагатай олон талт түншлэлийг хөгжүүлэх, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, ЭШУС хэлтсийн албан хаагчдаа улам чадавхжуулахыг зорьж, ингэснээр Ази Номхон далайн бүс нутгийн тэр дундаа Зүүн хойд Азийн орнуудад ЭШУС үйл ажиллагааны сайн туршлагын жишээ, загвар орон болох эрмэлзэлтэй ажиллаж байгаагаа илэрхийллээ.⁵⁹

5.1.3 Олон улсын төсөл хөтөлбөр

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн томилогдож, бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойших энэ хугацаанд чиг үүргийн хэрэгжилтийн явцад хэд хэдэн тулгамдсан асуудлыг тодорхойлон гаргаж ирээд байна.

Тухайлбал, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангахтай холбоотой үндэсний хууль тогтоомжуудын хоорондын уялдаа холбоог хангах, эрх зүйн тогтолцоог улам боловсронгуй болгох, ЭШУС хэлтсийн албан хаагчдыг хүн ам, газар нутгийн зохистой харьцаа, стандарттай уялдуулан хүний нөөцийн бодлогоор бүрдүүлэх, чадавхжуулах, ЭШУС үндэсний ажиллагааны төсвийн хараат бус байдлыг хангах зэрэг асуудлуудыг сайжруулах, шийдвэрлэх шаардлага бодитой тулгараад байна.

Иймд НҮБ-ын болон олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын дэмжлэгийг эрэлхийлэн, хамтран ажиллах бодлогыг баримтлан ажиллах хүрээнд:

- Нэмэлт протоколд нэгдэн орсон оролцогч улсуудын ЭШУС үндэсний ажиллагааг дэмжих үндсэн зорилгоор байгуулагдсан ЭШЭК-ын Нэмэлт протоколын Тусгай Сан⁶⁰-д МУ нь анх удаа буюу 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр “ЭШУС үндэсний ажиллагааг хэрэгжүүлэх, чадавхжуулах, бэхжүүлэх төсөл”-ийг илгээв.

Төслийн агуулга нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ийг хүртэл нэг жилийн хугацаанд дараах үндсэн гурван зорилгын хүрээнд хэрэгжих юм.

- ЭШУС үндэсний ажиллагааг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн сайжруулах, чадавхыг бэхжүүлэх,
- эрүү шүүлтээс ангид байх эрх, хүний эрхийн тухай боловсролыг дээшлүүлж, төрийн болон бусад холбогдох байгууллага, албан хаагчдын хүний эрхийг дээдлэх ёс зүй, хандлагад мэдэгдэхүйц ахиц гаргах,
- ЭШУС хэлтсийн албан хаагчдад болон үүрэг хүлээгч, төрийн албан хаагчдад зориулсан гарын авлагыг боловсруулах

5.1.4. Бусад улсын ЭШУС үндэсний механизмтай хамтран ажиллах талаар:

НҮБ-ын ЭШУС Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмжийн дагуу, ЭШЭК-ын Нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэх,

⁵⁹ Хүний эрхийн Үндэсний Комиссын ЭШУС хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангаас.

⁶⁰ The Special Fund of the Optional Protocol to the Convention against Torture | OHCHR

үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, цаашлаад хүний нөөцөө зохистой бүрдүүлэх, чадавхжуулахад онцгой анхаарал тавин ажиллахад бусад улсын ЭШУС үндэсний ажиллагаатай харилцаа тогтоож, сайн туршлага солилцох, хамтран ажиллахаар зорьж, эхний алхмуудыг хийгээд байна.

ЭШЭК-ын Нэмэлт протоколд оролцогч улсуудын ЭШУС үндэсний ажиллагааны байгуулагдсан бүтэц, чиг үүргээ хэрэгжүүлж байгаа шинэ арга барил, ЭШУС үндэсний ажиллагааны тухай хуулийн онцлог зэргийг судалж, дүгнэсний үндсэн дээр 10 гаруй улстай холбоо тогтоож, хамтран ажиллахыг зорьж байна.

Одоогоор НҮБ-ын ЭШУС Дэд хорооны гишүүдээр дамжуулан Итали, Гүрж улсуудтай холбоо тогтоон, хамтын ажиллагаагаа эхлүүлэхээр ажиллаж байна⁶¹.

Мөн ЭШЭК-ын Нэмэлт протоколын Тусгай сангийн дэмжлэгээр 2024 онд хэрэгжих төслийн хүрээнд ХБНГУ-ын ЭШУС үндэсний ажиллагааны сайн туршлагыг судлах ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.⁶²

5.1.5. Олон улсын хүний эрхийн бусад байгууллагын хамтын ажиллагаа

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд ОУБ, нийгэмлэг, сүлжээ байгууллагуудтай харилцан уялдаатай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьж байна.

Энэ нь шинэ тутам байгуулагдсан ЭШУС хэлтсийн албан хаагчдаа чадавхжуулах, чиг үүргээ далайцтай, хүртээмжтэй, бие даасан, хараат бусаар, үр дүнтэй явуулахад чухал ач холбогдолтой билээ.

Иймд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиг үүргийн Олон улсын 12 байгууллагыг хамарсан судалгаа, мэдээллийн санг бүрдүүлэн, эхний байгууллагуудтай холбоо тогтоон, хамтын ажиллагаагаа эхлэлийг тавихаар зорин ажиллаж байна. Тухайлбал:

• **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг** /Association for the Prevention of Torture/⁶³ нь 1977 онд Эрүү шүүлтийн эсрэг Швейцарын хороо нэртэйгээр анх байгуулагдаж байсан ба хожим өнөөгийн нэршлийг албажуулжээ.

ЭШУС тухай Европын конвенц 1987 онд батлагдсанаар тус байгууллага нь бүс нутгийн түвшинд амжилттай ажилласан туршлага дээрээ үндэслэн олон улсын түвшинд үйл ажиллагаагаа тэлснээр эрүү шүүлт болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авахад улс орнуудын ЗГ, хууль эрх зүйн тогтолцоо, ЭШУС үндэсний ажиллагаа, Хүний эрхийн Үндэсний байгууллагууд болон иргэний нийгмийг дэмжин ажиллаж эхэлжээ.

Тус нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга хатагтай Барбара Бернат бидний саналыг дуртайяа хүлээн авч, хамтарч ажиллахаа илэрхийлж дараах чиглэлээр хамтран ажиллах зорилт тавьж байгааг илтгэсэн.⁶⁴ Үүнд:

⁶¹<https://www.facebook.com/NPMMongolia/posts/pfbid02L7pTqvEF9QjG1AEsE1o27JyJifgKwyQRP6TfGWsQTGjjduNM4vJpo2WRZpDwaBXUI>

⁶² Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд илгээсэн 2024 онд 1 жилийн хугацаанд хэрэгжих “Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааг чадавхжуулах, үйл ажиллагааг бэхжүүлэх” төсөл.

⁶³ Association for the prevention of torture | Association for the Prevention of Torture (apt.ch)

⁶⁴<https://www.facebook.com/NPMMongolia/posts/pfbid02L7pTqvEF9QjG1AEsE1o27JyJifgKwyQRP6TfGWsQTGjjduNM4vJpo2WRZpDwaBXUI>

- “Мэдээлэл цуглуулах, мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ыг⁶⁵ Монгол Улсад нутагшуулах, хууль эрх зүйн хэрэглээнд нэвтрүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшихэд нөлөөлөл сургалт, сурталчилгааны ажилд хамтран ажиллах;
- ЭШУС үндэсний ажиллагааг үр дүнтэй явуулах, хэлтсийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн аливаа сургалт, семинарт оролцох, сайн туршлага судлах;
- ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний урилгаар Монгол Улсад танилцах, зөвлөгөө өгөх айлчлал хийх;

• **Эрүү шүүлтийн эсрэг санаачилга** /Anti-Torture Initiative/⁶⁶ байгууллага нь НҮБ-ын Эрүү шүүлтийн тусгай илтгэгч /2011-2016/ асан, хүний эрхийн хуулийн профессор Хуан Э.Мендезийн эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээг өргөжүүлэх, бодит хэрэгжилтийг нэмэгдүүлэх зорилгоор 2011 онд үүсгэн байгуулагдсан, Хүний эрх, хүмүүнлэгийн хуулийн төвийн үндсэн төсөл юм.

Уг байгууллагын хэрэгжүүлж буй стратеги, боловсруулсан арга барил маш богино хугацаанд эрүү шүүлттэй тэмцэх, эрүү шүүлтийн эсрэг дэлхийн хэмжээний хөдөлгөөний цар хүрээг гүнзгийрүүлж, өргөжүүлэх, урьдчилан сэргийлэх хүчин чармайлтад асар их нөлөө үзүүлжээ.

Хуан Э.Мендес⁶⁷ нь тусгай илтгэгч агсны бүрэн эрхийнхээ хүрээнд айлчлал хийсэн улс орнуудад зорилтот нөлөөлөл, техникийн туслалцаа, чадавхыг нэмэгдүүлэх сургалт, иргэний нийгмийн оролцоог хангах замаар улс орны онцлогтой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах стратегийн оролцоог хийдэг байна.

ЭШУС хэлтэс нь Хуан Э.Мендезийн санаачилга, удирдлагаар Эрүү шүүлтийн эсрэг санаачилга, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг, Норвегийн хүний эрхийн төв⁶⁸ байгууллагуудын хамтран боловсруулсан “Мэдээлэл цуглуулах, мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ыг Монгол Улсын мэдээлэл цуглуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах бүхий л байгууллага, албан тушаалтанд танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

Тухайлбал, 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдөр буюу “Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөр”-ийг тохиолдуулан “Мэдээлэл цуглуулах, мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ыг танилцуулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж ХЭҮК, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, АТГ, ЦЕГ, ШШГЕГ, ТЕГ, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, “Монголын Эмнести Интернэшнл” олон улсын байгууллага, Митчел сан, Дотоод хэргийн их сургууль зэрэг төрийн болон иргэний нийгмийн 15 байгууллагын төлөөлөгчид оролцсон.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн “Мэдээлэл цуглуулах, мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ын агуулга, үзэл баримтлалыг танилцуулж, төрийн болон иргэний нийгмийн байгууллага, их, дээд сургуулийн төлөөлөгчид уг зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж, байр сууриа илэрхийлцгээсэн.

⁶⁵ New Principles on Effective Interviewing for Investigations and Information Gathering | Association for the Prevention of Torture (apt.ch)

⁶⁶ Anti-Torture Initiative - American University Washington College of Law

⁶⁷ Juan Mendez, former Special rapporteur (2010-2016) | OHCHR

⁶⁸ Home - Norwegian Centre for Human Rights (uio.no)

Энэхүү уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд “Мэдээлэл цуглуулах, мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ыг Монгол Улсын хуулийн хэрэглээнд нэвтрүүлж, нэр томьёоны ойлголтыг нэг мөр болгох, хууль зүйн болон хууль сахиулахын их, дээд сургуулиудын сургалтын арга зүй, хөтөлбөрт тусгах зэргээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, дээд боловсролын байгууллагууд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудыг идэвхтэй оролцож, хамтран ажиллах Уриалга гаргасан юм.

Цаашид ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд “Эрүү шүүлтийн эсрэг санаачилга” байгууллагад дараах чиглэлээр хамтран ажиллахаар санал тавиад байна. Үүнд:

- “Мэдээлэл цуглуулах, мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ыг Монгол Улсад нутагшуулах, хууль эрх зүйн хэрэглээнд нэвтрүүлэх, төрийн болон ТББ, албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшихэд нөлөөлөл сургалт, сурталчилгааны ажилд хамтран ажиллах;
- ЭШУС үндэсний ажиллагааг үр дүнтэй явуулах, хэлтсийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн аливаа сургалт, семинарт оролцох, сайн туршлага судлах;

5.2. Иргэний нийгмийн болон ашгийн төлөө бус төрийн бус байгууллага, албан тушаалтан, иргэнтэй хамтран ажилласан талаар

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7 дахь заалтаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор ашгийн төлөө бус хуулийн этгээд болон бусад байгууллагатай хамтран ажиллах бүрэн эрхийг баталгаажуулсан.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний уг бүрэн эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллагын хяналт шинжилгээ, хэвлэл мэдээлэл, сургалт сурталчилгааны чиглэлийн нэгж, албан тушаалтантай харилцаа, холбоо тогтоох, хамтран ажиллах үйл ажиллагааг хэлтсийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, тайлангийн хугацаанд хэрэгжилтийг хангаж ажиллав. Үүнд:

5.2.1. Ашгийн төлөө бус төрийн байгууллагатай хамтран ажиллах талаар:

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон хэлтсийн албан хаагчид “Монголын Эмнести Интернэшнл” ОУБ-ын удирдлага, төлөөлөлтэй 2022 оны 09 дүгээр сарын 2, 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрүүдэд уулзалт, ярилцлага зохион байгуулж, тус байгууллагын үйл ажиллагаатай танилцан, иргэний эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах, ЭШУС үндэсний ажиллагааг чадавхжуулах хүрээнд хамтран ажиллах талаар ярилцсанаар цаашдын хамтын ажиллагааг эхлүүлээд байна.⁶⁹

- “Монголын Эмнести Интернэшнл” ОУБ-аас 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Дэлхийн хүний эрхийн төлөв байдал, Монгол Улс дахь тусгал” сэдэвт хэлэлцүүлэгт ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн оролцов.

- “Монголын ЛГБТ төв” ТББ-ын төлөөлөлтэй 2023 оны 02 дугаар сарын 6-ны өдөр уулзаж, хуульд заасан аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүхий л газарт “Бэлгийн цөөнх” хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, ялангуяа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг

⁶⁹ <https://www.facebook.com/aimongolia/>

хамгаалах сургалт, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах талаар харилцан тохиролцлоо.⁷⁰

- Дундговь аймаг дахь Ид шидийн орон төслийн багийнхантай 2022 оны 10 дугаар сарын 02-ны өдөр уулзаж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон хэлтсийн албан хаагч нар Ид шидийн орны бүтээн байгуулалтын явцтай танилцан, цаашид хамтран ажиллах талаар ярилцлаа⁷¹.

- ХЭҮК-ын гишүүн С.Дондов, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нар 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Б.Оюу-Эрдэнэ, Удирдах зөвлөлийн дарга Б.Баатарсайхан нартай уулзалт зохион байгуулж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх, ялангуяа гэмт хэрэг, зөрчилд шалгагдсан хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах талаар сургалт, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцов.⁷²

5.2.2. Холбогдох хурал, уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон байдал:

- ХЭҮК-ын дарга, гишүүд, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдөр улс төрийн намуудын төлөөлөлтэй уулзахад ЭШУС үндэсний ажиллагааны талаар мэдээлэл хийж хэлэлцүүлэг өрнүүлэв.

- Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвслээс хамтран зохион байгуулсан “Сурч боловсрох эрх: Боловсролын багц хуулийн төсөл” хэлэлцүүлэгт ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хэлтсийн албан хаагчид оролцож, санал солилцов.

- “Нээлттэй нийгэм Форум” “Оюуны-Инновац” ТББ-уудаас боловсруулсан “Монгол Улсын Шүүхийн индекс” судалгааны ажлын танилцуулах уулзалт, хэлэлцүүлэгт ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хэлтсийн албан хаагчид оролцлоо.

- “Монгол Улс дахь сэтгэцийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд” үндэсний чуулганд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн оролцов.

- 2022 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Монгол Улсын ХЭҮК, Ази Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулгантай хийсэн цахим Дээд хэмжээний уулзалтад ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн оролцож, ХЭҮК-ын шинэ мандат болох ЭШУС үндэсний ажиллагааг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах зэрэг асуудлаар хэлэлцүүлэгт оролцлоо.

Иргэний нийгэм нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд гол үүргийг гүйцэтгэдэг.

Төрөөс хараат бус, хөндлөнгийн нөлөөлөлд автдаггүй гэдгээрээ зарим тохиолдолд ЭШУС үндэсний ажиллагаанаас урьтаж эрүү шүүлтийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл иргэний нийгмийн байгууллагуудад түрүүлж хүрсэн байх тохиолдол бий.

Иймд хяналт шинжилгээ, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангах ЭШУС үндэсний ажиллагааны нэг үүрэг юм.

⁷⁰<https://www.facebook.com/npmmongolia/posts/pfbid0aikdartlvysuxenswmmazsjs5uub22ryze5kms3fmuf37tnk9c4dxohlme9yf2l>

⁷¹<https://www.facebook.com/idShidiinOronDundgovi/posts/pfbid024BgaYwfMHMh5GuTbXmEf4j4HrwSWEd6snuBrUdmA6WG44qcMNGWiJSUiMUMjRrURI>

⁷² Монголын Өмгөөлөгчдийн Холбооны удирдлагуудтай уулзав - ХЭҮК (nhrcm.gov.mn)

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон ЭШУС хэлтэс нь хүний эрх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, тухайлбал, эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн “Монголын Эмнести Интернэшнл” ОУБ, “Монголын ЛГБТ төв” болон бусад төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудтай сүлжээ үүсгэн, хамтын ажиллагаагаа жигдрүүлэх зорилготой ажиллаж байна.

Үр дүнтэй, мэргэшсэн хамтын ажиллагааг иргэний нийгмийн байгууллагуудтай тогтоож, тогтмолжуулж чадвал ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд чухал түлхэц өгч чадах юм.

5.3. ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага

ЭШУС үндэсний ажиллагаа нь ЭШУС олон улсын байгууллагуудын ажлыг нөхөх гол үүрэг гүйцэтгэдэг.

Үүний тулд түүнд чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх эрх мэдэл олгох ёстой. Ийм учраас Нэмэлт протоколын төслийг боловсруулагчид ЭШУС үндэсний ажиллагааны хараат бус байдал, бүрэн эрх, төсвийг хараат бусаар шууд захиран зарцуулах эрхийг олгох талаар оролцогч улсуудын өмнө хүлээсэн эрх зүйн үүргийг заасан.

Нэмэлт протоколын 4 дүгээр хэсэгт тусгаснаар оролцогч улс нь ҮУСБ-ыг байгуулахдаа:

- Үйл ажиллагааны бие даасан хараат бус байдал
- Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавх бүхий мэргэшсэн байх
- Үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах нөөцтэй байх гэсэн баталгааг бүрдүүлэх үүрэг хүлээсэн.

Монгол Улсад ЭШУС үндэсний ажиллагааг олон улсын жишиг хандлагад нийцүүлэн бэхжүүлэх асуудлаар дараах асуудлыг судлан холбогдох арга хэмжээг авч өгнө үү. Үүнд:

5.3.1. ЭШУС нэгжийн албан хаагчдын хүний нөөцийн асуудлаар:

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллана.”, энэ зүйлийн 36.3 дахь хэсэгт “..зөвхөн энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, Комиссын Тамгын газар нь ЭШУС нэгжийг 10 албан хаагчтай ажиллахаар нөөцийн асуудлаа зохион байгуулж, ТАЗ-ийн 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” тогтоолуудыг үндэслэн “Албан тушаалын тодорхойлолт”-уудыг баталсан байна.

ХЭҮК-ын болон ЭШУС үндэсний ажиллагааны төсвийг УИХ-ын ХЗБХ-ны хурлаар хэлэлцэхэд хорооны гишүүн Б.Энхбаяр нь: “..шинэ тутам байгуулагдаж байгаа ЭШУС нэгжийн төсөв, орон тоог дэмжиж, хасалгүйгээр батлах” тухай санал гаргаж, энэхүү санал дэмжигдсэн. ХЗБХ-ны ахлах зөвлөхөөр удирдуулсан төсөв хянах хурлаар улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор ХЭҮК-ын нэмэгдэж батлагдаж байгаа 93 орон тооноос 10 орон тоог 2023 оны төсвийн төсөөлөлд хасхаар шийдвэрлэснээс ЭШУС нэгжийн 5 албан хаагчийн төсвийг хассан. Мөн үйл ажиллагааны төсөв ч хасагдсан.

ХЗБХ-ны ахлах зөвлөх ЭШУС нэгжийн албан хаагчдыг үйл ажиллагааны цар хүрээ, тогтмол уулзах хүний тоо, туулах зам зэрэгтэй холбогдуулан жил бүр орон тоогоо

нэмэгдүүлж явах боломжтой гэдгийг илэрхийлсэн. ЭШУС үндэсний үйл ажиллагааг дэмжин 2022 оны төсөвт 5 орон тоотой ажиллахаар тусгасан нөхцөлийг дээрдүүлж, бүтэн орон тоогоор, эсвэл орон тоог жил бүр нэмэгдүүлнэ гэсэн ХЗБХ-ны даргын санал, хуралдааны шийдвэр хэрэгжиж эхэлнэ гэдэгт итгэлтэй байна.

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн ЭШУС үндэсний ажиллагааны талаарх урьдчилсан дүгнэлтэд “... *“Монгол Улс Эрүүдэн Шүүхийн Эсрэг Конвенцын Нэмэлт Протоколыг 2015 онд соёрхон баталсан бөгөөд хэдийгээр хожуу ч гэсэн уг конвенцын дагуу Үндэсний Урьдчилан Сэргийлэх Механизм (цаашид ҮУСМ гэх) бий болгосныг Ажлын хэсэг талархан сайшааж байна.*

Монгол Улсын ҮУСМ-ын бүрэн эрхийг ХЭҮК-ын тухайлсан ажлыг хариуцсан комиссар хэрэгжүүлэхээр зохицуулсан байна.

Энэ нь комиссын бүрэн эрхийн хугацаанд томилогдсон Комиссын гишүүний чиг үүрэгт багтсан байнгын үүрэг бөгөөд уг ажлыг шинээр байгуулагдсан ҮУСМ-ын алба хариуцан гүйцэтгэх юм. Тийн хэдий ч уг нэгжийг янз бүрийн салбарын 10 мэргэжилтнээс бүрдүүлэн ажиллуулж төсөв хэмнэх шаардлага тавигдаж байгаа тул эхний хоёр жилийн хугацаанд ердөө таван орон тоотой ажиллахаар байгаа нь бидний санааг зовоож байна.

Түүгээр ч зогсохгүй ҮУСМ-ын албаны ажилтнуудыг сонгон шалгаруулахад Төрийн албаны зөвлөл ямар үүрэг гүйцэтгэж байгаа, энэ асуудалд ҮУСМ-ын асуудал эрхэлсэн комиссар тун бага эрх мэдэлтэй оролцохоор байгаад Ажлын хэсэг санаа зовниж байна.

Ажлын хэсэг ҮУСМ-ын бие даан ажиллах чадамжийг хангахын чухлыг онцолж, ҮУСМ-ын боловсон хүчнийг сонгохдоо бие даасан байдлыг нь хангаж өгөхийг Засгийн газарт хүсэлт болгож байна. Монгол Улсын газар зүйн байрлалтай уялдан дур зоргоор эрх чөлөөг хязгаарлах зарим газрын алслагдсан байршлаас шалтгаалан ҮУСМ-ын албыг яаралтай арван хүний бүрэлдэхүүнтэй ажиллах бололцоог бүрдүүлэх нь маш чухал юм. ” гэж урьдчилсан байдлаар дүгнэжээ.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхэд энэ зүйлийн 34.1.9 “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн даргыг томилох, чөлөөлөх,” гэж заасан, харин ЭШУС нэгжийн албан хаагчдыг гишүүн, эсвэл нэгжийн дарга томилох асуудал дээр хууль хэрэглээний үл ойлгогдох байдалтай байна.

Цаашид ЭШУС үндэсний ажиллагааг хууль, Монгол Улсын Олон улсын гэрээнд заасны дагуу хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангах арга хэмжээг хууль, эрх зүйн хүрээнд нэг мөр шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

5.3.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсвийн үр нөлөөтэй, хараат бус байх талаар:

НҮБ-ын ЭШЭК-ын Нэмэлт протокол нь гэрээг хэрэгжүүлэх үндэсний байгууллага болох ЭШУС үндэсний ажиллагааны эрх, үүргийг бататгасан анхны баримт бичиг юм.

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас тус конвенц, түүний нэмэлт протоколд нэгдэн орсон улсууд, эрх баригч нарт хандан дараах зөвлөмжийг хүргүүлж үүнийгээ албан ёсны вэбсайт дээрээ байршуулсан. Үүнийг сийрүүлбэл: ЭШУС байгууллага (Монгол Улсын хувьд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгж) нь ЭШУС олон улсын байгууллагуудын ажлыг нөхөх гол үүрэг гүйцэтгэдэг. Үүний тулд түүнд чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх эрх мэдэл олгох ёстой.

Ийм учраас Нэмэлт протоколын төслийг боловсруулагчид эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хараат бус байдал, бүрэн эрх, төсвийг хараат бусаар шууд захиран зарцуулах эрхийг олгох талаар оролцогч улсуудын өмнө хүлээсэн эрх зүйн үүргийг заасан.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэж хуульчилсан.

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн ЭШУС үндэсний ажиллагааны талаарх урьдчилсан дүгнэлтэд “...ҮУСМ-ын албанд ногдох төсвийг ХЭҮК-ын нэгдсэн төсөвт тусгаж өгсөн нь эерэг үзүүлэлт гэдгийг Ажлын хэсэгт тэмдэглэж байна. Гэвч ХЭҮК-ын Тэргүүн комиссар болон Тамгын газрын даргын зөвшөөрөлгүйгээр ҮУСМ-ын ажилд зориулагдсан санхүүжилтийг ажил эрхэлсэн Комиссар бие даан захиран зарцуулах бололцоогүй байгаа нь ҮУСМ-ыг санхүүгийн бүрэн бие даасан гэж үзэх боломжгүй байдалтай болгож байгаад Ажлын хэсэг ихээхэн санаа зовниж байна.

Энэ нь эрх чөлөөгөө хасуулсан газруудад гэнэтийн шалгалт хийх ҮУСМ-ын бүрэн эрхэд зайлшгүй шаардагдах ажилд онцгой сөрөг нөлөө үзүүлж байна. Ажлын хэсэг ҮУСМ-ыг санхүүгийн хараат бус, ялангуяа гэнэтийн шалгалт хийх бүрэн бололцоо, чадвартай болгохыг Засгийн газарт уриалж байна.

Ажлын хэсэг ХЭҮК, ҮУСМ тэдгээр ангиудад очиж ажилладаг талаар мэдээлэл авч байсан бөгөөд энэ нь нэн сайшаалтай хэрэг юм. Ажлын хэсэг эрх чөлөөг нь дур мэдэн хасахаас урьдчилан сэргийлэхэд байнгын хараат бус хяналт чухал үүрэгтэйг тэмдэглэж, ХЭҮК, ҮУСМ-ын чиг үүргээ бие даан, үр дүнтэй хэрэгжүүлэх чадамжийг цаашид бэхжүүлэхийг Засгийн газарт анхааруулж байна. Үүний тулд ҮУСМ-ын бүрэн эрхээ үр дүнтэй, бие даан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, түүний мэдэлд байгаа санхүүгийн эх үүсвэрийг цаашид нэмэгдүүлэхийг Ажлын хэсэг анхааруулж байна..... Эдгээр нь Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтүүд юм.” гэж урьдчилсан байдлаар дүгнэжээ.

Эрүү шүүлт хүнлэг бус, хэрцгий, доромжлох хандлага, шийтгэлээс ангид байх эрхийг хамгаалахтай холбоотой олон тулгамдсан асуудлыг “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх илтгэл”-үүд,⁷³ “ЭШЭК-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын хоёрдугаар илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж” (2016), “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 сарын 11-ээс 20-ны өдрүүдэд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмжүүд” (2017)-д тусгасан яаралтай шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замд төсвийн талаар онцлон тусгасан.

Тухайлбал: “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эдийн засгийн баталгааг хангах, уг үйл ажиллагааны төсвийг өмнөх оныхоос бууруулахыг хориглохыг хуульчлах” гэж зөвлөсөн.

⁷³ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 13 дахь илтгэл (ХЭҮК, 2014), 68-91; Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 14 дэх илтгэл (ХЭҮК, 2015), 7-60; Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 15 дахь илтгэл (ХЭҮК, 2016), 9-4; Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 16 дахь илтгэл (ХЭҮК, 2017), 140-152; Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 17 дахь илтгэл (ХЭҮК, 2018), 170-175; Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 18 дахь илтгэл (ХЭҮК, 2019), 139-170; Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 19 дэх илтгэл (ХЭҮК, 2020), 180-186;

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулиар ЭШУС үйл ажиллагаа эдийн засгийн хувьд хараат бус хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна.⁷⁴

2022, 2023 онд Комиссын нэмэгдүүлсэн орон тооноос 10 орон тооны төсвийг хасах болсонтой холбогдуулан Комиссын удирдлагын шийдвэрээр 5 орон тоо хасагдаж өмнөх оны төсөвтэй харьцуулахад ЭШУС үндэсний ажиллагааны төсөв нэмэгдээгүй зэргээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний саналыг харгалзалгүй орон тоо, цалингийн сан, үйл ажиллагааны зардлыг холбогдох албан тушаалтнууд өөрчилжээ.

Энэ нь Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг “Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно”, энэ зүйлийн 31.3 дахь хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэж заасан баталгаануудыг зөрчсөн төдийгүй НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж” (2016), “ЭШУС Дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 сарын 11-ээс 20-ны өдрүүдэд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмжүүд” (2017) биелэгдээгүй байна.

Түүнчлэн “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын санаачилгаар хийж бидэнд албан ёсоор танилцуулсан 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Бие даасан институтийн төсөв, санхүүгийн хараат бус байдалд хийх дүн шинжилгээ” судалгааны тайланд дараах дүгнэлт хийгдсэн. Үүнд:

- ХЭҮК болон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь бие даасан хоёр институт болох ч Төсвийн тухай хуульд зааснаар төсөв, санхүүгийн хараат бус байдал нь бодитой, тодорхой хэрэгжих боломжгүй байна. Тодруулбал, Төсвийн тухай хуульд зааснаар ХЭҮК-ын дарга нь төсвийн ерөнхийлөн захирагч болж, ХЭҮК-ын Тамгын газрын дарга нь төсвийн шууд захирагч болдог.

- ХЭҮК-ын төсвийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон УИХ-ын ХЗБХ хянан зөвшөөрөл өгөхдөө ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний төсвийг үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхүйц байх шаардлагыг харгалзах шаардлагатай.

- ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны хараат бус байдлыг хуульчилсан ч төсөв, санхүүгийн хувьд бусад этгээдийн оролцоотой байх эрсдэлтэй байна.

Иймд Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэж, ЭШУС үндэсний ажиллагааг хууль, Монгол Улсын Олон улсын гэрээнд заасны дагуу хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангах арга хэмжээг хууль, эрх зүйн хүрээнд авч, шийдвэрлэн зохицуулах бодит шаардлага үүсээд байна.

⁷⁴ Мөнхсайхан.О., “Хүний эрхийн үндэсний комиссын болон ЭШУС үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдал: сонгон шалгаруулалт ба төсөв” Хууль дээдлэх ёс. №03 (82) ХЗҮХ, 2021., 21-53 дахь тал.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд Монгол Улсаас конвенцын хэрэгжилтийн талаар хүргүүлэх ээлжит гурав дахь удаагийн тайлан/2020/-гийн дүгнэлтэд “ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Монгол Улсын ХЭҮК-ын бүтцэд бий болгох эрх зүйн үндсийг тавьсан нь тус улсад ЭШУС бие даасан, хараат бус механизм бий олох эрх зүйн орчныг бүрдүүллээ.”, Монгол Улсын Засгийн газар ЭШЭК-ын дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах тал дээр хүчин чармайлт гаргаж байгаа болно.” гэж тусгагдсан билээ.

ЭШУС хэлтэс нь ЭШЭК, түүний нэмэлт протокол, Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд заасан зарчимд нийцүүлэн ЭШУС үндэсний ажиллагааны стратеги боловсруулан, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд **“Эрүү шүүлтгүй Монголын төлөө”** гэсэн алсын харааг зорьж, эрүү шүүлтээс ангид байх эрхийг зөрчиж болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судалж, ЭШУС үндэсний ажиллагааг үр нөлөөтэй, бодитой, хүртээмжтэй зохион байгуулахад үндэсний болон бүс нутгийн хэмжээнд манлайлагч нь байх эрхэм зорилгыг тавьж дараах стратегийг баримтлан ажиллаж байна. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагаа бүхий тогтолцоог бэхжүүлэх;
- ЭШУС ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах;
- Хяналт шинжилгээг тогтмол, үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Хүн бүрд эрүү шүүлтээс ангид байх эрхийг нь мэдүүлэх;
- ЭШУС зарчмын хэрэгжилтийг хангуулах.

Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд өөрийн хүслээр гарч явах боломжгүй нөхцөлд байгаа ойролцоогоор 37000 гаруй хүнд тогтмол хүрэлцэж хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг хууль, олон улсын гэрээнд зааснаар хийх шаардлагатай байгаа бөгөөд энэхүү урьдчилан сэргийлэх ажлыг шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын удирдлага, тэдгээрийн алба хаагчдын хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлэх боломжтой юм.

2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс хойш нэгжийн 5 албан хаагчтайгаар СЭМҮТ-ийн ШСЭСК, Асрамжийн тасгууд, АНҮТ, ШШГЕГ-ын харьяа төв, орон нутагт байрлах хорих анги, цагдан хорих хаалттай 461 дүгээр анги, баривчлах байр, цагдан хорих байр зэрэг нийт 23 газар орон, байршилд батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ хийсэн.

Тухайлбал, Хяналт шинжилгээний хүрээнд 48 ажилтан, алба хаагч, хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдсон, баривчлагдсан 411 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийж, өөрийн хүслээр гарч явах боломжгүй нөхцөлд байгаа нийт 1,954 хүнээс асуумж авч, 209 хүнд зөвлөгөө өгч, харьяаллын дагуу 6 гомдлыг шилжүүлэн шалгууллаа.

Хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд тогтоогдсон эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж болзошгүй байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 11 зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг тооцон, ЭШУС үндэсний ажиллагааны талаар тухай бүр албан ёсны цахим хуудсаар олон нийтэд мэдээлж ирлээ.

Мөн шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын алба хаагч, зорилтот бүлгийн иргэд буюу нийт 3357 хүнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн асуудлаар сургалтууд хийж, эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 8 удаа сурталчлан ажилласан.

Түүнчлэн ЭШУС үндэсний ажиллагааны тайлангийн хугацааны хэрэгжилт, НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн ЭШУС үндэсний ажиллагааны талаарх урьдчилсан дүгнэлт, “Бие даасан институтын төсөв, санхүүгийн хараат бус байдалд хийх дүн шинжилгээ” судалгаагаар ХЭҮК болон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь бие даасан хоёр институт болох ч Төсвийн тухай хуульд зааснаар төсөв, санхүүгийн хараат бус байдал нь бодитой, тодорхой хэрэгжих боломжгүй төдийгүй ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны хараат бус байдлыг хуульчилсан ч төсөв, санхүүгийн хувьд бусад этгээдийн оролцоотой байх эрсдэлтэй байна.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн Ажлын хэсгийн 36 дугаар чуулган⁷⁵-аар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр бусад улсаас дараах зөвлөмжийг ирүүлжээ. Үүнд:

“...ЭШЭК-ын нэмэлт протоколд заасны дагуу ЭШУС үндэсний механизм бий болгох үйл явцыг хурдасгах ... (Мексик), ... хүний эрх чөлөөг хязгаарладаг бүхий л газарт хараат бусаар тогтмол хийх хяналт, шалгалтыг бэхжүүлэх (Норвеги); ... эрүү шүүлт, тэр дундаа эрх чөлөөг нь хассан хүнийг эрүүдэн шүүсэнтэй холбоотой гомдлыг шалган шийдвэрлэх бие даасан, үр дүнтэй процедур бий болгох (Мексик, Франц, Польш, Румын); ... Эрүүдэн шүүх, хүний нэр төрийг гутаан доромжилсон хэргийг мөрдөн шалгах бие даасан байгууллага байгуулах (Мальдив, Ботсвана, Испани); ... ЭШУС тэр дундаа шүүгч, прокурор, болон ажилтнуудад зориулан сургалт тогтмол явуулах замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг бэхжүүлэх (Индонез);

Цаашид НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, ЭШУС Дэд хорооноос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, хамтран ажиллах, олон улсын туршлагыг практикт нэвтрүүлэх, бүс нутгийн болон олон улсын сүлжээ байгууллагуудтай олон талт түншлэлийг хөгжүүлэх, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, ЭШУС судалгааны ажлыг шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагатай хамтран хийх, хэлтсийн албан хаагчдыг чадавхжуулан хяналт шинжилгээ, сургалт, сурталчилгааг тогтмолжуулан ажиллахаар зорилт тавин ажиллаж байна.

⁷⁵ <https://www.upr-mongolia.mn/?cmd=Content&menuid=41&id=227>. 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг механизмаар 3 дахь удаа хэлэлцээд 170 зөвлөмж өглөө.

ДОЛОО. САНАЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протокол, Монгол Улсын Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн чухлыг эргэн санаж, НҮБ-ын хүний эрхийн механизм, тэдгээрийн хараат бус шинжээч, ажлын хэсгийн зөвлөмжийг гарцаагүй хэрэгжүүлэх шаардлагатайг анхаарч, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа Монгол Улсад шинээр бүрэлдэн бий болж байгаа эмзэг цаг үе гэдгийг мэдэрч, маш олон хаалттай хаалганы цаана байгаа хүмүүсийн эрхийг хамгаалахыг чухалчлан, хууль тогтоогч, ОУБ, ТББ, хүний эрхийн болон нийгмийн зүтгэлтэн, судлаач, иргэдийн оролцоо, дэмжлэг нэн хэрэгтэй байгааг тодотгон, ХЭҮК-н тухай хууль, бусад хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тулгарч буй сорил, бэрхшээлүүдийг шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

"Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын нэмэлт протокол"-ын 19 дүгээр зүйлийн с), Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2. дахь хэсэгт заасныг үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

7.1. 2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлийн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг ЭШЭК-ын 1 дүгээр зүйлийн бүх элементүүдийг багтааж өөрчлөх;

7.2. "Эрүүдэн шүүх" үйлдлийг Эрүүгийн хуульд 4 төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд оруулсан нь гэмт хэргийн зүйлчлэлд тодорхойгүй байдлыг үүсгэж байгаа тул Конвенцын дагуу "эрүүдэн шүүх" гэмт хэргийг оновчтой тодорхойлж, ялыг чангатгах;

7.3. ЭХХШТ хуулиар эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байхаар зохицуулсан боловч мэдүүлгээс бусад нотлох баримтыг эрүү шүүлт тулгаж авсан ч нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг тухайн хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулах замаар өөрчлөх;

7.4. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх үндэслэлийг нарийвчлан, тодорхой болгон өөрчлөх;

7.5. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар, шударгаар мөрдөн шалгах бие даасан албыг НҮБ-ын бүх шаардлагад нийцүүлэн нэн даруй байгуулах, ингэхдээ тусгай субъектийн үйлдсэн бүх хэргийг бус зөвхөн эрүүдэн шүүх, зүй бус харьцаатай холбоотой мөрдөн шалгах эрхийг олгох замаар дагнасан, мэргэшсэн, цомхон байх боломжийг хангах, мөрдөн шалгах бүрэн эрх, хараат бус байдал, хангалттай төсөв олгох асуудлыг судлан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;

7.6. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол гаргах;

7.7. НҮБ-ын ЭШУС Дэд хороо Монгол Улсад 2017 онд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмжид тусгагдсан Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын үйл ажиллагаа явуулах бие даасан, хараат бус байдлыг ЭШЭК-ын нэмэлт протоколын дагуу баталгаажуулах. Тухайлбал, Монгол Улсын Төрийн албаны тухай, Төсвийн тухай хууль тогтоомжийг энэ механизмын хүрээнд хэрэгжүүлэх зарчмуудыг нарийвчлан тодорхойлох;

7.8. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгжийн ажиллах орон тоог нэмэгдүүлэх, албан хаагчдад тавигдах шаардлагыг ЭШЭК-ын нэмэлт

протоколд заасны дагуу бүрдүүлэх, Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд зааснаар нэгжийн даргын нэгэн адил албан хаагчдыг томилох эрх бүхий албан тушаалтан нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн байх гэж хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагад чиглэл хүргүүлэн шийдвэрлэх.

НАЙМ. ХАВСРАЛТ №1

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагууд

№	Байгууллагын нэр	Товч танилцуулга
1	European Committee for the Prevention of Torture and Inhuman or Degrading Treatment or Punishment /CPT/ Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх Европын Хороо	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх Европын конвенцод заасны дагуу эрх чөлөөгөө хасуулсан бүхий л газруудад хяналт шалгалт хийх эрх бүхий олон улсын Хороо байгуулагдсан бөгөөд Европын зөвлөлийн хараат бус, бие даасан байгууллага юм. CPT нь Европын холбооны нэг хэсэг биш боловч Европын 46 улсыг өөртөө нэгтгэсэн Европын зөвлөлд хамаардаг. Европын холбоо нь хууль эрх зүйн баримт бичвэр боловсруулахдаа мөн гишүүн болон гишүүн бус улс орнуудтай харилцахдаа CPT-ийн зөвлөмжийг ихэвчлэн ашигладаг ⁷⁶ .
2	Organization for Security and Cooperation in Europe Office for Democratic Institutions and Human Rights /OSCE-ODIHR/ Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилсан институт, Хүний эрхийн Алба	Европын Аюулгүй Байдлын Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилсан институт, Хүний эрхийн Алба нь гишүүн орнуудад хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн хангахад туслах, хууль дээдлэх, ардчиллын зарчмыг сурталчлах, ардчилсан институтийг бий болгох, бэхжүүлэх, хамгаалах, мөн нийгэмд ялгаварлан гадуурхалтыг үл тэвчихэд дэмжин туслах үүрэгтэй алба юм ⁷⁷ .
3	European Union Agency for Fundamental Rights /FRA/ Европын Холбооны /хүний/ Үндсэн эрхийн агентлаг	Хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр судалгаа, зөвлөгөө, мэдээллийн үйл ажиллагаа явуулдаг бие даасан байгууллага. Хүний эрхийг хамгаалах тал дээр орон нутгаас эхлээд олон улсын түвшинд оролцогч талуудтай хамтран ажилладаг. Тус байгууллагын нотолгоонд суурилсан мэргэжилтний зөвлөгөө, судалгаа, мэдээллийг олон улсын түвшинд бодлого, шийдвэр гаргагчид авч хэрэглэдэг ⁷⁸ .
	Association for the Prevention of Torture	Үүсгэн байгуулагч Jean-Jacques Gautier нь 1977 онд тус байгууллагыг Эрүүдэн шүүлтийн эсрэг Швейцарын хороо

⁷⁶ European Committee for the Prevention of Torture and Inhuman or Degrading Treatment or Punishment (CPT) - CPT (coe.int)

⁷⁷ OSCE Office for Democratic Institutions and Human Rights | OSCE

⁷⁸ Home – BMEIA, Austrian Ministry of Foreign Affairs

4	/APT/ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Нийгэмлэг	нэртэйгээр анх байгуулж байсан ба одоогийн нэршил нь ЭШУС Нийгэмлэг болжээ. ЭШУС тухай Европын конвенц 1987 онд батлагдсанаар тус байгууллага нь бүс нутгийн түвшинд амжилттай ажилласан туршлага дээрээ үндэслэн олон улсын түвшинд үйл ажиллагаагаа тэлсэн. Тус нийгэмлэг нь ЭШУС үр дүнтэй арга хэмжээ авахад улс орнуудын Засгийн газар, хууль эрх зүйн тогтолцоо, Урьдчилан сэргийлэх Үндэсний механизм, Хүний эрхийн Үндэсний байгууллагууд болон иргэний нийгмийг дэмжин ажилладаг.
5	European Commission - Human Rights Trust Fund /HRTF/ Европын зөвлөлийн Хүний эрхийн Итгэлцлийн Сан	Хүний эрхийн Итгэлцлийн Санг (HRTF) 2008 оны 3 дугаар сард Норвег улс, Европын Зөвлөл болон Европын Зөвлөлийн Хөгжлийн Банктай хамтран байгуулсан. Сан нь Европын хүний эрхийн конвенц болон хүний эрхийн бусад стандартын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд улс орнуудын хүчин чармайлтыг санхүүжүүлэхэд гол зорилго нь оршдог⁷⁹.
6	Human Rights Implementation Centre of the University of the Bristol /HRIC/ Бристолын их сургуулийн Хүний эрхийн хэрэгжилтийн төв	Хүний эрхийн хэрэгжилтийн төв нь Их Британийн Бристолын Их сургуулийн дэргэд 2009 онд байгуулагдсан. Тус төвийн зорилго нь хүний эрхийн хэрэгжилтийг дэлхийн даяар хэрхэн бэхжүүлэх талаар илүү сайн ойлголтыг бий болгохын тулд олон улс, бүс нутаг, үндэсний түвшинд байгууллага, институтүүдтэй хамтран ажиллах явдал юм. Хамтын ажиллагааны нэг чиглэл нь ЭШЭК-ын Нэмэлт протокол, ЭШУС хүний эрхийн хэрэгжилт юм. - ҮУСМ-ыг тодорхойлох, үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад чиглэгдсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа хийх; -ЭШУС талаар ойлголт өгөх зорилготой олон улсын, бүс нутгийн болон үндэсний хэмжээний бага хурал, семинарууд зохион байгуулдаг; - ҮУСМ-ыг үр дүнтэй ажиллуулахад туслах зорилгоор Засгийн газар, Хүний эрхийн үндэсний байгууллага, ҮУСМ болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, зөвлөгөө өгөх; -Эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцахыг хориглох, урьдчилан сэргийлэх стандартын хэрэгжилтийг бэхжүүлэх чиглэлээр олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажиллах; -Эрүү шүүлт тулгах шинжийг гэмт хэрэгт тооцоход чиглэсэн хууль тогтоомжийг боловсруулахад туслах зөвлөгөө өгөх⁸⁰.
7	The World Organization Against Torture /SOS – Torture Network /OMCT/	ОМСТ нь эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцахыг таслан зогсоох, хохирогчдод туслах, эрсдэлд байгаа хүний эрхийг хамгаалагчдыг хаана ч байсан хамгаалах зорилгоор 200 гишүүн байгууллагатай хамтран ажилладаг. Тус байгууллагын эгнээнд дэлхийн 90 гаруй улсад эрүүдэн шүүхийн эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг томоохон бүлгүүд багтдаг. SOS Torture Network сүлжээний гишүүдтэй хамтран улс орнуудын Засгийн газруудад эрүү шүүлтээс

⁷⁹ Human Rights Trust Fund - Directorate of Programme Co-ordination (coe.int)

⁸⁰ Human Rights Implementation Centre | University of Bristol Law School | University of Bristol

	Эрүү шүүлтийн эсрэг Дэлхийн байгууллага /SOS-Эрүү шүүлтийн сүлжээ байгууллага/	урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу гэмт хэрэг гэж үзэх, гэмт хэрэгтнүүдийг шүүхэд өгөхийн зэрэгцээ хохирогчдод нөхөн төлбөр олгох, нөхөн сэргээх зэрэг арга хэмжээг авахад шахалт үзүүлэн үр дүнд хүрэхийг зорьж ажилладаг ⁸¹ .
8	Centre for human rights and humanitarian law - Anti-Torture Initiative /ATI/ Хүний эрх, хүмүүнлэгийн хуулийн төвийн Эрүү шүүлтийн эсрэг санаачилга	Эрүү шүүлтийн эсрэг санаачилга (ATI) нь НҮБ-ын Эрүү шүүлтийн тусгай илтгэгч /2011-2016/ /асан, Хүний эрхийн хуулийн профессор Juan E. Méndez -ийн эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээг өргөжүүлэх, бодит хэрэгжилтийг нэмэгдүүлэх зорилгоор 2011 онд үүсгэн байгуулагдсан Хүний эрх, хүмүүнлэгийн хуулийн төвийн үндсэн төсөл юм. ATI-ийн хэрэгжүүлж буй стратеги, боловсруулсан арга барил маш богино хугацаанд эрүү шүүлттэй тэмцэх, эрүү шүүлтийн эсрэг дэлхийн хэмжээний хөдөлгөөний цар хүрээг гүнзгийрүүлж, өргөжүүлэх, урьдчилан сэргийлэх хүчин чармайлтад асар их нөлөө үзүүлсэн. ATI нь профессор Juan E. Méndez-ийн айлчлал хийсэн улс орнуудад зорилтот нөлөөлөл, техникийн туслалцаа, чадавхыг нэмэгдүүлэх сургалт, иргэний нийгмийн оролцоог хангах замаар улс орны онцлогтой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах стратегийн оролцоог хийдэг.
9	Norwegian Human Rights Fund /NHRF/ Норвегийн Хүний эрхийн сан	Норвегийн Хүний эрхийн сан нь 1988 онд Jan Egeland-ын санаачилгаар Норвегийн иргэний нийгэм, академи, ажилчдын үйлдвэрчний эвлэлийн оролцоотой байгуулагдсан. Тус Сан нь хүний эрхийг хамгаалах тэргүүн шугамын байгууллагуудад шууд дэмжлэг үзүүлэх замаар хүний эрхийг олон улсын хэмжээнд хамгаалах, дэмжих чиглэлээр ажилладаг. Гол зорилго нь хүний эрхийн зөрчил, шударга бус явдалд өртөж буй гадуурхагдсан, эмзэг бүлгийн хүмүүс болон бусад бүлгүүд өөрсдийн эрхээ нэхэмжилж, эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх. Мөн хүний эрхийн зөрчигддөг газар ажилладаг байгууллага, институтыг дэмждэг ⁸² .
10	Internation Federation For Human Rights /FIDH/ Олон улсын Хүний эрхийн Нийгэмлэг	FIDH нь 1922 онд байгуулагдсан, 177 орны 188 төрийн бус байгууллагыг нэгтгэдэг Олон Улсын Хүний Эрхийн Нийгэмлэг /ТББ/ юм. Байгуулагдсан цагаасаа хойш FIDH нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан иргэний, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхийг хамгаалсаар ирсэн. FIDH нь Хүний эрхийг хамгаалагч орон нутгийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, Хүний эрхийн болон Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй үйл явдлуудаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийн дэмжлэгийн санг удирддаг ⁸³ .
	DIGNITY	DIGNITY нь 1982 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд дэлхийн хамгийн анхны эрүүдэн шүүхийн эсрэг төрийн бус

⁸¹ Our network | OMCT

⁸² The Norwegian Human Rights Fund (nhrf.no)

⁸³ International Federation for Human Rights (fidh.org)

11	Дани улсын төрийн бус байгууллага	байгууллага, эрүүдэн шүүхээс амьд үлдсэн хүмүүст зориулсан тусгай эмчилгээний төв юм. 40 жилийн турш тус байгууллага нь эрүүдэн шүүхтэй тэмцэх дэлхийн тэргүүлэгч иргэний нийгмийн байгууллага байсаар иржээ. Тус байгууллага нь дэлхийн хэмжээнд 140 орчим ажилтантай, 30 гаруй дотоодын болон олон улсын төрийн бус байгууллага, судалгааны байгууллагатай идэвхтэй хамтын ажиллагаа өрнүүлдэг. Алсын хараа нь: Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлох болон харгислалгүй дэлхий ⁸⁴ .
12	Human Rights Platform HRP Хүний эрхийн Платформ	Хүний эрхийн платформ нь “хүний эрхийг ямагт хүндэтгэж, илүү шударга, эрх тэгш, ардчилсан, хүртээмжтэй нийгмийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах” зорилгоор Европын холбооны санхүүжилтээр 2021 оны 10 сард төсөл болон хэрэгжиж эхэлсэн бөгөөд Хүний эрхийн платформ нийгэмлэг хэрэгжүүлдэг. Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий долоон байгууллагын оролцоотойгоор байгуулагдсан Хүний эрхийн платформ нь "Хяналт-шинжилгээ, тайлагналт, нөлөөлөл", "Хүмүүсийг чадавхжуулах", "Мэдээлэл, мэдлэг, чадавхыг бэхжүүлэх", "Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх" гэсэн үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг: -Хяналт-шинжилгээ, тайлагнах, өмгөөлөл: Хүний эрхийн хэрэгжилт, эрх зөрчигдсөн байдалд хяналт тавьж, тайлагнаж, ил тод болгож, хүлээсэн үүргийн биелэлтийг орон нутаг, бүс нутаг, олон улсын түвшинд сурталчлан хамгаалдаг. -Хүмүүсийг чадавхжуулах: Эрх, эрх чөлөө нь зөрчигдөж байгаа, гадуурхагдсан, гадуурхагдах магадлалтай хувь хүн, бүлгийг дэмжих; тэдний өөрийгөө өмгөөлөх үйл ажиллагааг дэмжин туслах. -Мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх: Хүний эрх, ардчилалд суурилсан асуудлаар шийдвэр гаргагчид, төрийн байгууллагууд, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллагууд зэрэг гол оролцогчдын чадавхыг бэхжүүлдэг. -Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх: Хүний эрх, эрх чөлөөний янз бүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрхэд суурилсан байгууллагуудтай харилцан суралцах, эв санааны нэгдэлтэй байх, нийтлэг мөрийн хөтөлбөрийг бий болгох, дэмжих; олон улсын, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд хамтын ажиллагаа, түншлэлийг бий болгож, дэмжих ⁸⁵ .

⁸⁴ Kontakt - DIGNITY - Danish Institute Against Torture

⁸⁵ About Us - Human Rights Platform (insanhaklariplatformu.eu)

Хавсралт №2: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд зохион байгуулсан сургалт хамтран ажилласан байгууллага, хамрагдсан хүний тоо

№	Байгууллага, арга хэмжээ	Сургалтын сэдэв	Хамрагдсан хүний тоо	Сургалтын хэлбэр
	<i>2022 он</i>			
1	Хуульчдын үргэлжилсэн сургалт	- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа”; - “Хуульчийн мэргэжлийн хариуцлага”	60 нотариатч	Танхим
2	Улсын ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төв	- “Мэдүүлэг, ярилцлага авах Мендезийн зарчим”	97 прокурор	Танхимын болон цахим хосолсон
3	ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, баривчлах байр Ахмад настны үндэсний төв Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай аймаг дахь ШШГГ, хэлтэс, Цагдаагийн газар, хэлтэс	- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа”; - Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжид тусгагдсан нь”; - “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх”; - “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа”	1,505 албан тушаалтан, ажилтан, алба хаагч нийгмийн хамгааллын салбарын төрөлжсөн асрамжийн ажилтнууд	Танхим
<i>2023 он</i>				
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги	- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга”; - “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангах асуудал”;	215 алба хаагч	Танхим

		- “Олон улсын гэрээ конвенцод тусгагдсан эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх”; - “Харилцаа ба сэтгэл хөдлөл”		
5	Нийслэлийн цагдаагийн удирдах газар Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөл	- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга”; - “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангах асуудал”	50 алба хаагч; Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн 15 гишүүн	Танхим
6	Чингэлтэй дүүргийн Прокурорын газартай хамтарсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг	- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга”; - “Эрүү шүүлтийн эсрэг конвенц, түүний нэмэлт протоколын хэрэгжилтийн зарим асуудал”; - “Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт”; - “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн”	Дүүргийн прокурорууд, Мөрдөн байцаах тасгийн мөрдөгчид, Мөрдөн байцаах албаны мөрдөгчид, Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн алба хаагчид нийт 120 хүн	Танхим
7	Нийслэлийн цагдаагийн удирдах газраас зохион байгуулсан “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж биеэ авч явах чадваргүй иргэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь” хэлэлцүүлэг	- “Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх, түр саатуулах байранд хүний эрхийг хангах асуудал”	ХЗДХЯ, ЭМЯ, ГССҮТ, Түлэгдлийн төв, НЭМГ, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба болон нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн	Танхимын болон цахим хосолсон

			Цагдаагийн газар, хэлтсийн нийт 1,200 хүн	
8	Нийслэлийн Баянзүрх дүүргийн Цагдаагийн газраас зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь” сургалт, хэлэлцүүлэг	- “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь”	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 95 алба хаагч	Танхим
	Нийт		3,357	

***Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай
хуулийн 7 дугаар бүлэг, 31 дүгээр зүйл:***

*31.4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн
Гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны
тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд
танилцуулж, хэвлэн нийтэлнэ.*



nmpt.gov.mn



www.facebook.com/NPMMongolia



+976 51-263129, 11-327136